

**ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙДЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД  
ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁОГ**

№	Санал ирүүлсэн	Саналын утга	Саналыг тусгасан байдал
1.	Шүүхийн зөвлөл	Хуулийн төсөлд хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаатай холбоотойгоор “үр ашигтай байх”, “хэмнэлттэй байх”, “хурдан шуурхай байх” гэх мэт зарчмыг нэмэлтээр тусгах.	Саналыг тусгаагүй.
		5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг  Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд гуравдагч этгээдийг хэргийн оролцогчоор оруулах, эсхүл холбогдох хуулийн дагуу шүүхээс оролцуулахаар заасан этгээдийг гэж нэмж оруулах.	Саналыг тусгаагүй.
		Хуулийн төсөлд дурдагдсан нэр томъёонууд процессын хуультай зөрчилдөх, зохицуулалтгүй орхигдож болзошгүй байна. Тухайлбал, хуулийн төсөлд хэргийн оролцогч гэдэгт үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, хэрэг гүйцэтгэгч хамаарахаар байна. Харин ИХШХШТХ-д тухайн маргаантай асуудлаар эрх, ашиг нь хөндөгдөж байгаа гуравдагч этгээд нь хэргийн оролцогч болдог. Мөн нэхэмжлэл гаргах эрхтэй ч оролцох тохиолдол бий.	
		9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг  "... ажиллагааны талаар нийтэд мэдээлэхээр энэ хуульд нэрлэн заасан мэдээлэл гэж тодотгоод энэ хуульд өөрөөр заагаагүй бол шүүхийн болон хуулийн этгээдийн ... гэж найруулах  Одоогийн төслөөр ойлгомжгүй, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаатай холбоотой бүх мэдээллийг мэдээлэхээр ойлгогдож болзошгүй байна.	Саналыг тусгаагүй.
		10 дугаар зүйл 10.1 дэх хэсэг  Хэргийн оролцогчийн бүрэлдэхүүн болоод эрх ашиг нь хөндөгдөж байгаа гэх мэтчилэн шинжээр нь гомдол гаргах эрхтэй субъектийг тодорхойлох	Саналыг тусгаагүй.

		Холбогдох этгээд гэдгийг хэн гэж ойлгох нь тодорхойгүй болжээ. Ийм тодорхойгүй нөхцөлд гомдлыг хүлээн авч буй шүүх бүрэлдэхүүний эрх хэмжээнд хамаарч, хэнийг гомдох эрхтэй, эрхгүйгээр ялгах нөхцөл үүснэ. Анхнаасаа тодорхой шинжээр нь зохицуулж өгөх саналтай байна. Жишээлбэл, гомдлыг ерөнхий зарчмын хувьд эрх, ашиг нь хөндөгдөөгүй этгээд гаргах ёсгүй, холбогдох этгээд гэдэг нь холбоотой бүх этгээд гэж ойлгогдохоор байна.	
		10 дугаар зүйл 10.2 дахь хэсэг  ... тав хоногийн дотор гэснийг арав хоногийн дотор..." гэж өөрчлөх эсхүл ажлын тав хоног гэж өөрчлөх  Хугацааны хувьд ерөнхий 5 хоногийн хугацаа хангалтгүй байдаг. Уг хугацааг захирамжийг холбогдох этгээд мэдэх боломжит хугацаа байсан эсэх, хэрэгтэйгээ танилцаад гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжтой юу гэдгээс шалтгаална. Амралтын өдрүүд орохгүйгээр тооцох нь гомдол гаргах эрхийг хэрэгжүүлэхэд үр дүнтэй. Жишээлбэл практикт гомдол гаргах 5 хоног нь амралтын 2 өдөр, Үндэсний их баяр наадмын өдрүүд таарсан тохиолдол гарч байсан.	Саналыг тусгасан.
		Хүндэтгэн үзэх шалтгаан байгаа тохиолдолд гомдол гаргах хугацаа хэтэрснийг сэргээх зохицуулалт нэмэх  Одоогоор гомдол гаргах хугацааг сэргээх үндсэн нөхцөл юу байх талаар эсхүл сэргээж болох/болохгүй эсэх дээр тодорхой зохицуулалт хуулийн төсөлд байхгүй байна. Аль ч тохиолдолд хугацаа сэргээх эрх нь гомдолтой талын процессын хэрэгжүүлэх эрх байх нь зүйтэй юм. Иймд давах буюу хянуулах процессын эрхээр хангагдах нөхцөлийг хангахаар хугацаа сэргээх зохицуулалт нэмэх шаардлагатай.	Саналыг тусгаагүй. Олон улсын жишигт нийцүүлсэн.
		17 дугаар зүйл 17.2 дахь хэсэг  Үүрэг гүйцэтгэгч өөрөө шүүхэд хүсэлт гаргасан бол агуулгын хувьд өртэй этгээдийн жагсаалтад дурдсан этгээдүүд гэж нэмэх.	Саналыг тусгаагүй.

		Шүүх ямар тохиолдолд мэдэх боломжтой вэ гэвэл холбогдох нотлох баримтуудыг татан үзсэний дараагаар тодорхойлох боломжтой болно. Иймд эхний ээлжид хүсэлт гаргаж байгаа этгээдийн гаргасан жагсаалтад заасан этгээдэд хүргүүлэх боломжтой байхаар тусгах нь зүйтэй.	
		27 дугаар зүйл 27.2 дахь хэсэг  "... Засгийн газрын гишүүн, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална." гэж өөрчлөх  Хэрэг гүйцэтгэгчийн эрхийг хууль зүйн асуудал хариуцсан захиргааны төв байгууллага өөрөө баталсан журмаараа олгохоор төсөлд тусгагджээ. Хэрэг гүйцэтгэгчид санхүүгийн мэдлэг боловсролтой хүн, хуулийн этгээд гэдэг шалгуур байгаа атал дангаар Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дангаар батлах нь мэргэжлийн боловсон хүчний хувьд хэр чадамжтай талаар анхаарах хэрэгтэй.	Саналыг тусгасан.
		47 дугаар зүйл  Саналын эрхийн асуудлаар шүүхэд гомдол гаргасан бол үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болохгүй байх буюу түдгэлзэх зохицуулалтыг нэмэх	Саналыг тусгаагүй.
		83 дугаар зүйл  "Хуваарилалтын ажиллагаа" гэх үгийг өөр оновчтой, ойлгомжтой нэр томъёогоор илэрхийлэх "Хуваарилах ажиллагаа", "Хөрөнгө хуваарилах ажиллагаа" гэж өөрчлөх	Саналыг тусгаагүй.
		83 дугаар зүйл 83.3 дахь хэсэг  Хуваарилагдах хөрөнгөнд мөнгөн хөрөнгө бий болсон тухай бүр хуваарилалтыг явуулж болох ба бэлэн мөнгийг хөрөнгө худалдаж дуусахаас өмнө хуваарилж болно" гэснийг "мөнгөн хөрөнгө бий болсон бол тухай бүр хуваарилж болох ба бэлэн мөнгийг эд хөрөнгө худалдаж дуусахаас өмнө хуваарилна" гэж өөрчлөх	Саналыг тусгасан.
2.	Санхүүгийн зохицуулах хороо	Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг тус Хороо зарчмын хувьд дэмжиж байгаа	Саналыг тусгаагүй.

	2025.05.01 2/1625	<p>бөгөөд хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна.</p> <p>1. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах;</p> <p>"3.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан зохицуулалттай этгээд болон банк бус санхүүгийн байгууллага, даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, хадгаламж, зээлийн хоршоо, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, уул уурхайн бүтээгдэхүүний бирж, биржийн арилжааны зуучлагч /брокер/, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой хуулиар тусгайлан зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна."</p>	
		<p>2. Ажилтны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийн хамгаалалтыг сайжруулах;</p> <p>Хуулийн төслийн 84 дүгээр зүйлийн 84.1.3, 84.1.4-т заасан нэхэмжлэлийн шаардлага хангах дараалалд ажилтны хөдөлмөрийн хөлс болон түүнтэй холбоотой шимтгэлийн өрийн дараалал, хамгаалалтыг олон улсын жишигт нийцүүлэх талаар дахин нягтлах хэрэгтэй байна. Энэ талаар хуулийн төсөлд ажилтны цалин, олговрын өрийг татварын ногдол, татварын өр, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, алданги, хүү, торгуулийн дараа хангуулахаар зохицуулсан байна.</p> <p>Гэвч олон улсын туршлагын дагуу ажилтнуудын хөдөлмөрийн хөлс, түүнтэй холбогдох нийгмийн хамгааллын шимтгэлийг татварын өрнөөс өмнө төлөгдөх давуу эрхтэй болгох нь зүйтэй гэж үзэж байна.</p> <p>Ажил олгогчийн төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэл нь ажилтан хувь хүний тэтгэвэр, тэтгэмжтэй шууд холбоотой байдаг тул энэ өрийг энгийн татварын өртэй адилтган үзэхээс илүүтэй ажилтны хөдөлмөрийн нөхцөл, шаардлагын нэг</p>	Саналыг тусгасан.

		хэсэг юм. Ингэснээр ажилтны цалин хөлс, түүнтэй холбоотой шимтгэлийн өр нэг багц болж, татварын өрнөөс өмнө хангагдсанаар ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах боломжтой юм.	
3.	Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.04.29 УИХ-03/5328	1.Хуулийн төсөлд хуулийн хамрах хүрээг хязгаарлаж, Үнэт цаасны Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1, 24.1.2, 24.1.4, 24.1.5, 24.1.7, 24.1.8, 24.1.9, 24.1.10, 24.1.11, 24.1.12, 24.1.13, 24.1.14-т заасан зохицуулалттай этгээд болон банк бус санхүүгийн байгууллага, даатгагч, хадгаламж зээлийн хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой харилцааг тус тусынх нь хуулиар тусгайлан зохицуулж, тэдгээрээс бусад харилцааг нь Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулиар зохицуулахаар тусгажээ. Ингэснээр хууль хоорондын зөрчил, хууль хэрэглээний хувьд хүндрэл үүсэх зэрэг сөрөг үр дагавар бий болж болзошгүй байна. Иймд төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой харилцааг гол хуульдаа цогцоор нь зохицуулж, хуульчлах нь эдгээр асуудлаас зайлсхийх ач холбогдолтой юм.	Саналыг тусгаагүй. Онцлог зохицуулалтыг олон улсад зохицуулдаг.
		2.Хуулийн төсөлд нэг этгээд, эсхүл хурлыг эрхлэн гүйцэтгэх үйл ажиллагаагаар нь олон янзаар нэрлэн "түр хэрэг гүйцэтгэгч", "хэрэг гүйцэтгэгч" гэх мэтээр ангилж, нарийвчлан зохицуулах шаардлагагүй асуудлыг хэт нарийвчлах замаар хууль хэрэглээг төвөгтэй, ойлгомжгүй болгожээ. Нөгөөтээгүүр, аливаа этгээдийн үйлдэл, үйл ажиллагаа хийх, шийдвэр гаргах явцыг нарийвчлан зохицуулж, тодорхойлон эрэмбэлэх шаардлагатай тохиолдлуудыг мөн ерөнхийлөн зохицуулсан байна. Иймд хуулийн төсөлд зайлшгүй тусгах шаардлагатай, чухал зохицуулалтуудыг судлан, төсөлд оновчтой тусгах шаардлагатай.	Саналыг тусгаагүй.
		3.Хуулийн төслийн бүтэц, агуулга, системчлэл эмх цэгцгүй, ойлгомжгүй байгааг дахин зохион байгуулж, логик дараалал, уялдаа холбоо, зөв бүтэцтэй болгох нь зүйтэй.	Саналыг тусгасан.
		4.Хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолт, тайлбар зэргийг хангалттай хийгээгүйгээс гадна тухайн нэр томъёог төслийн турш хэрэглэх боловч тодорхойлолт нь төслийн дунд байх гэх мэтийг анхаарах шаардлагатай байна. Иймд хуулийн төсөлд нэр томъёо, тайлбарыг бүрэн гүйцэт, зохих ёсоор тусгавал зохино.	Зарчмын хувьд тусгасан.
		5.Шүүгч, үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурал, хэрэг гүйцэтгэгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэх мэт этгээдүүдийн эрх, үүрэг, гүйцэтгэх ажил үүргийг	Саналыг тусгаагүй. Олон улсын

		зарим тохиолдолд тухайн асуудлыг үл хариуцах этгээдэд (шүүгчийн үүргийг хэрэг гүйцэтгэгчид ногдуулах гэх мэтээр) олгосон зохицуулалтууд байгааг анхаарах шаардлагатай.	жишигт нийцүүлсэн.
		6.Төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийг дахин зохион байгуулах ажиллагаанд хуулийн этгээдийг өөрчлөн зохион байгуулах асуудал хамаарах эсэхийг тодорхой болгох нь зүйтэй. Жишээ нь групп компанийн нэг охин компани төлбөрийн чадваргүй болсныг дахин зохион байгуулах төлөвлөгөөгөөр толгой компани өөртөө нэгтгэх санал гаргавал хэрхэн зохицуулах нь тодорхойгүй байна. Толгой компанийн хувьд уг компанийн үйл ажиллагаа, туршлага чухал ач холбогдолтой байж болох юм.	Хуулийн төсөлд тусгасан.
		7.Хуулийн төслийн 23 дугаар зүйлд "Үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадваргүй болсон шалтгааныг тодруулах" гэсэн зохицуулалт орсон. Уг агуулгыг нь харвал шүүх урьдчилж шүүх хуралдаан хийж төлбөрийн чадваргүй болсон шалтгааныг тодорхойлох зорилготой эрх зүйн хэм хэмжээ байна. Гэтэл энэхүү зохицуулалт нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шүүхэд мэдүүлэх, шүүх хөндлөнгийн байх зарчмыг хөндөхөөр байна. Мөн хуулийн төсөл бүхэлдээ тухайн хуулийн этгээдийг төлбөрийн чадваргүй болсон эсэхийг тогтоох зорилготой байхад урьдчилж хурал хийнэ гэдэг нь логикийн хувьд алдаатай байна.	Саналыг тусгаагүй. Олон улсын жишигт нийцүүлсэн.
4.	Монгол дахь Америкийн Худалдааны төв 2025.04.30 2025/35	4-р зүйл хуулийн нэр томъёоны тодорхойлох зүйл  4.1.1. "үүрэг гүйцэтгүүлэгч" гэж үүрэг гүйцэтгэгчээс Үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийг;  Төслийн 12.1-д үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгчийг төлбөрийн чадваргүйд тооцуулах хүсэлтийг шүүхэд гаргах эрх нээлттэй байх үндэслэлийн нэг нь хууль, эсхүл гэрээнд заасан мөнгөн төлбөрийн үүргээ тасралтгүй 6 сараас дээш хугацаагаар биелүүлж чадаагүй тохиолдолд гэж заасан байна. Энэ нь төлбөрийн үүрэг шаардаж буй өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч үүрэг гүйцэтгэгчийг төлбөрийн чадваргүйдэлд тооцуулахаар шүүхэд өгөх эрх нээлттэй байна.  Төлбөрийн үүргээ 6 сар тасралтгүй төлөөгүй байх үндэслэлээр шүүхэд хандан	Саналыг тусгасан.

	<p>татан буулгах замаар өөрсдийн төлбөрийн үүргийн шаардлагыг гарах нь үүрэг гүйцэтгэгчийг үйл ажиллагааг дэмжих бус улам санхүүгийн хүнд нөхцөлд оруулах нөхцөл бүрдэж байна гэж харж байна.</p> <p>Ялангуяа банк, банк бус санхүүгийн байгууллагаас зээл авч, үйл ажиллагаа явуулж буй зээлийн төлбөрийн үүргийн харилцаанд үүсэх нөлөө өндөр байна.</p> <p>Иймд төслийн 4-р зүйл, Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо нь үүрэг гүйцэтгүүлэгчид хамаарахгүй байх эсхүл ялгамжтай байлгах зохицуулалтаар тусгаж өгөх саналтай байна.</p>	
	<p>12 дугаар зүйл. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргах этгээд</p> <p>12.2. Үүрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэх удирдлага төлбөрийн чадваргүй болсныг мэдсэн буюу мэдэх боломжтой байсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг шүүхэд гаргах үүрэгтэй.</p> <p>Гүйцэтгэх удирдлага нь Компанийн тухай хуулийн 83.1-т зааснаар компанийн дүрэм болон ТУЗ, байхгүй бол хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан эрхтэй байдаг. Гүйцэтгэх удирдлага нь тус хуулиар ТУЗ, хувьцаа эзэмшигчийн хурлаас илүү эрх хэмжээг олгож байгаа нь эрсдэлтэй. Иймд ТУЗ, ХЭ шийдвэр, тогтоолд үндэслэн гэж тусгах нь зүйтэй байна.</p> <p>Өмнөх хуулиар тус зохицуулалт тусгагдаагүй байсан болно.</p>	Саналыг тусгаагүй. Компани тухай хуулиар хэрэгжинэ.
	<p>Хөрөнгө оруулагчийг хамгаалах талаар</p> <p>Хуулийн төсөлд тусгагдаагүй болно.</p> <p>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг татан үйл ажиллагаагаа явуулж, дуусгавар болох хугацаанд /хөрөнгө оруулах, зээл олгох, хувьцаа худалдан авах гэх мэт/, үр ашгийг</p>	

	<p>хүртэхээс өмнө болон дараа нь алдагдалтай ажиллах хугацаанд хөрөнгө оруулагч бус үүрэг гүйцэтгүүлэгч төслийн 22.1-д заасан үндэслэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчийг төлбөрийн чадваргүйдэлд тооцуулах хүсэлтийг шүүхэд гаргаж болохоор байна. Гэтэл хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхлыг хэрхэн хамгаалах талаар энэ хуулийн төсөлд огт дурдаагүй байна. Хөрөнгө оруулагчийг хамгаалах зохицуулалтыг тусгах саналтай байна.</p>	
	<p>Төслийн 16.1. Шүүх хүсэлтийг 10 хоногийн дотор хянаж, энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан татгалзах үндэслэл байхгүй бол урьдчилсан төлбөр төлөхийг хүсэлт гаргагчид даалгаж, энэ тухай захирамж гаргана гэж заасан. Тус заалтын дагуу үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтийг шүүх хүлээн аваад тэмдэгтийн хураамж төлөх тухай захирамж гарсны дараа төслийн 18.2-т заасан арга хэмжээ авах эрхийг шүүгч дангаар эдэлнэ гэж заасан.</p> <p>Үүнээс хөрөнгөө удирдах, захиран зарцуулахыг хориглох, өөрийн санаачилгаар, эсхүл түр хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааг бүрэн, эсхүл хэсэгчлэн зогсоох эрхийг үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадвартай эсэхийг урьдчилсан байдлаар судлаагүй байж энэхүү эрхийг хэрэгжүүлж байгаа нь үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааг доголдуулах, хуулийн этгээдийг хясан боогдуулах арга хэмжээ болж байна. Нөгөөтээгүүр шүүхийн хараат бус байдал алдагдах нөхцөл бүрдэнэ. Иймээс бүхэлд нь шүүгчийн 18.2-т заасан эрхийг төслөөс хасах саналтай байна.</p>	Зарчмын хувьд тусгасан.
	<p>19-р зүйл. Түр хэрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэх үйл ажиллагаа</p> <p>19.1. Түр хэрэг гүйцэтгэгч томилогдсон өдрөөсөө хойш 20 хоногийн дотор дараах асуудлаар тус бүрийн талаар дүгнэлт гаргаж шүүхэд ирүүлнэ:</p> <p>19.1.1 үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадвартай эсэх</p> <p>Үүнд үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадвартай эсэхийг ямар шалгуур нөхцөл, үзүүлэлтийн дагуу судлан дүгнэлт гаргах талаар тодорхой тусгуулах саналтай байна.</p>	Хуулийн төслийн 22 дугаар зүйлд тусгасан. Зарчмын хувьд тусгасан.
	20 дугаар зүйл. Түр хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлтийн улмаас үүсэх үр дагавар	Саналыг тусгаагүй.



	<p>20.1. Түр хэрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгэгч нь төлбөрийн чадвартай, эсхүл үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй, түүний хөрөнгө төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлыг төлөх боломжгүй гэсэн дүгнэлт гаргасан бол шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэхээс татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргана.</p> <p>Тус заалтаас эсхүл үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй, түүний хөрөнгө төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлыг төлөх боломжгүй гэснийг хасах, үндсэн агуулгатай зөрчилдөж байна.</p>	
	<p>20.4. Урьдчилсан төлбөр төлсөн этгээд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргах үүргээ зөрчсөн энэ хуулийн 12.2-т заасан үүрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэх удирдлагаас төлбөрийг шаардах эрхтэй.</p> <p>ТУЗ, Хувьцаа эзэмшигчдийн тогтоол батлагдсан хугацаанаас хойш хугацаанд тус урьдчилсан төлбөр төлсөн этгээд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргах үүргээ биелүүлээгүй зөрчсөн бол төлбөрийг шаардах эрхтэй байхаар тусгах эсхүл үүрэг гүйцэтгэгчээс шаардах гэдгээр тусгах;</p>	Саналыг тусгаагүй.
	<p>22 дугаар зүйл. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх үндэслэл</p> <p>22.1. Дараах нөхцөлийн аль нэг бүрдсэн тохиолдолд хуулийн этгээдийг төлбөрийн чадваргүйд тооцож, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлнэ:</p> <p>22.1.1.хууль, эсхүл гэрээнд төлбөрийн үүргээ үргэлжилсэн хугацаагаар заасан мөнгөн зургаан сараас дээш биелүүлж чадаагүй;</p> <p>22.1.2. нийт өр төлбөр нь хуулийн этгээдийн санхүүгийн тайланд тусгагдсан нийт хөрөнгийн дүнгийн 50 хувиас хэтэрсэн</p> <p>Тооцох эсэхийг шийдвэрлэхээр гэж гэж өөрчлөх</p> <p>Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх 22.1-д заасан үндэслэлд</p>	Саналыг тусгасан.

	<p>шүүхийн шийдвэр гүйцэтгэлд төлбөрийн үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нь тогтоогдсон гэж нэмэх саналтай байна.</p> <p>Ингэснээр шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаагаар буюу тухайн шаардлагыг шүүхээс эцэслэн төлбөр төлөх үүрэгтэй болохыг нь тогтоосны дараа мөн гүйцэтгэх ажиллагааны явцад баримтаар тогтоогдсон хуулийн этгээдийг төлбөрийн чадваргүйд тооцох асуудлыг тус хуулиар шийдвэрлэх боломж бүрдэнэ.</p> <p>Үүний дагуу 13-р зүйлийн 13.3-т "Үүрэг гүйцэтгүүлэгчийн тухай шаардлага талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөрийн үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болох нь тогтоогдсон баримт/ гэж нэмж тусгах</p> <p>22.1-д заалтын аль нэг нь бүрдсэн гэж үзвэл үүрэг гүйцэтгүүлэгчийн санаатай нэг үйлдэл үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөхөөр байна.</p> <p>Иргэний хуульд гэрээний үүрэг буюу төлбөрийн үүрэгтэй холбоотой шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа 3 жил гэж заасан гэтэл энэ хугацаанаас урьдаж 6 сараар дээш хугацаагаар төлбөрийн үүргээ гүйцэтгээгүй гэдгээр шүүхэд хандах тохиолдлуудыг нэмэгдэж, үүрэг гүйцэтгэгчийг эрх зөрчигдөж, төлбөрийн чадваргүйдэлд тооцуулах нөхцөлд хүргэх сөрөг үр дагаврыг бий болгож болох юм.</p> <p>Иймээс 22.1.1-д заасан ....6 сараас дээш хугацаа гэснийг 1 жилээс дээш хугацаагаар гэж өөрчлөх саналтай байна.</p> <p>Төслийн 22.1.2-т заасан үндэслэлээр шүүхэд зөвхөн үүрэг гүйцэтгэгч хүсэлт гаргах эрхтэй гэж нэмэх саналтай байна. Мөн Санхүүгийн тайланг орлогын дүнгээс хамаарч хуулийн этгээд жилд 1-4 удаа гаргадаг. Санхүүгийн тайланд тусгагдсан. гэдгийг хэдэн удаа гэж үзэх вэ? Энэ талаар тодорхой тусгах саналтай байна. Үйл ажиллагааны онцлог үүнд нөлөөлөх үү.</p>	Саналыг тусгасан.
	25 дугаар зүйл. Хэрэг гүйцэтгэгчид тавигдах	Саналыг тусгасан.

		<p>25.2.Хэрэг гүйцэтгэгч дараах шалгуурыг хангасан байна:</p> <p>25.2.1.хууль, санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэл, аудит, эсхүл бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан;</p> <p>25.2.1-д ... мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан гэж өөрчлөх</p> <p>Хуулийн этгээдийг төлбөрийн чадваргүйдэл тооцох эсэхийг тус Хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлтээр тодорхойлохоор заасан. Иймээс шалгуурыг өндөрсгөх нь алдаа мадаг гаргахгүй байх нөхцөл бүрдэх юм.</p>	
		<p>26 дугаар зүйл. Хэрэг гүйцэтгэгчийн бүрэн эрх</p> <p>26.2. Хэрэг гүйцэтгэгч энэ хуулийн 26.1-д заасан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан мэргэшсэн шинжээч хөлсөөр ажиллуулж болно</p> <p>Хэрэг гүйцэтгэгч нь олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй аливаа нэг асуудлаар мэргэшсэн шинжээчийн дүгнэлт гаргах шаардлага үүсэх тохиолдолд өөрөө бие дааж шийдвэрлэх бус, маргаан үүсгэхгүй байх, хараат бус байдлыг хангах үүднээс шүүхэд хүсэлт гаргах замаар, шүүгчийн захирамжаар шийдвэрлэх зохицуулалтыг тусгах саналтай байна.</p>	Саналыг тусгаагүй.
		<p>8 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамж төлөх</p> <p>8.2. Нэхэмжлэлийн шаардлагын талаар өмнө гарсан шүүхийн шийдвэртэй бол улсын тэмдэгтийн хураамж төлөхгүй.</p> <p>8.2. Нэхэмжлэлийн шаардлага гаргаж байгаа этгээдийн тус нэхэмжлэлийн шаардлагад иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл нэхэмжлэлийн шаардлагын талаар өмнө гарсан шүүхийн шийдвэртэй бол улсын тэмдэгтийн хураамж төлөхгүй.</p>	Саналыг тусгаагүй. Улсын тэмдэгтийн хураамжийн хуулиар заавал хэрэг бүрд төлнө.
		<p>8.3. Нэхэмжлэлийн шаардлага гаргаж байгаа этгээдийн нэхэмжлэлийн шаардлага маргаантай бол улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 72.2-т</p>	Саналыг тусгаагүй.

		<p>заасан хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлөх бөгөөд маргааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.</p> <p>Энэ тохиолдолд Шүүгчийн захирамжаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 72.1-т заасны дагуу төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгоно.</p>	
		<p>11 дүгээр зүйл. Төлбөрийн чадваргүйдлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал</p> <p>Хуулийн төсөлд тусгагдаагүй болно.</p> <p>11.3. Үүрэг гүйцэтгэгч нь нэг хувьцаа эзэмшигчтэй ба хувьцаа эзэмшигч нь гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлдэг тохиолдолд хувьцаа эзэмшигчийн оршин суугаа газрын иргэний хэргийн анхан шатны шүүх хянан шийдвэрлэж болно.</p>	Саналыг тусгаагүй. Хуулийн төсөлд тусгасан.
		<p>46 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлын ирц, шийдвэр хүчин төгөлдөх болох</p> <p>46.2. Энэ хуулийн 46.1 заасан ирц хүрээгүйн улмаас үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлыг 20 хойшлуулсан бол хойшлогдсон хурал нь саналын эрхийн 20-оос дээш хувийг эзэмшиж байгаа үүрэг гүйцэтгүүлэгч ирснээр хүчин төгөлдөр болно.</p> <p>дахин нэг удаа хойшлох эрх олгох</p> <p>Тайлбар: 20 хувиар шийдвэр гаргах нь бусад үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрх ашигт сөрөг нөлөөтэй байж болох тул дахин нэг удаа хойшлуулсан тохиолдолд 20 хувь байхаар зохицуулах саналтай байна.</p>	Саналыг тусгаагүй. Нөгөө талд хариуцлага байх хэрэгтэй.
		<p>85 дугаар зүйл. Хэсэгчилсэн 14 хуваарилалтад хамрагдах нэхэмжлэлийн шаардлагын хувь хэмжээг тогтоох</p>	

	<p>85.1. Хуваарилалтын хамрагдах нэхэмжлэлийн шаардлагын хувь хэмжээг хэрэг гүйцэтгэлийн саналыг үндэслэн үүрэг гүйцэтгүүлэгчдийн зөвлөл тогтооно. Зөвлөлгүй бол хэрэг гүйцэтгэгч тогтооно.</p> <p>... Зөвлөлгүй бол хэрэг гүйцэтгэгчийн саналыг үндэслэн үүрэг гүйцэтгүүлэгчийн хурал тогтооно.</p> <p>Тайлбар:</p> <p>Энэ нь нэхэмжлэгчдийн эрх ашгийн асуудлыг шийдвэрлэж байгаа тул хурлаар шийдвэрлэх саналтай байна.</p>	
	<p>99 дүгээр зүйл. Төлбөрийн чадваргүйдлийн үйл ажиллагааг зогсоох журам</p> <p>99.3. Энэ хуулийн 99.1-д заасан хүсэлтийн талаар нийтэд мэдээлснээс хойш 10 хоногийн дотор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны үүрэг гүйцэтгүүлэгчид хүсэлтийг эс зөвшөөрвөл шүүхэд хандаж болно.</p> <p>Үүрэг гүйцэтгүүлэгчид хүсэлт гаргах эрхийг хэрэгжүүлэх хангалттай хугацаа олгох үүднээс 14 хоног болгох саналтай байна.</p>	Саналыг тусгасан.
	<p>100 дугаар зүйл. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоосны үр дагавар</p> <p>Хуулийн төсөлд тусгагдаагүй болно.</p> <p>Шүүхийн шийдвэр, захирамж гарсны дараа ямар хугацаанд гомдол гаргах эрхтэй нь тодорхой бус байгаа тул гомдол гаргах хугацааг тусгаж өгөх.</p>	
	<p>118 дугаар зүйл. Төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болох</p> <p>118.1.3. Үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа сэргээх нөхцөл бүрдээгүй, эсхүл төлөвлөгөө хэрэгжих явцад үйл ажиллагаа алдагдалтай үргэлжилж байгаа Зарим төлөвлөгөө хэсэг хугацааны дараа ашгаа өгөх боломжтой тул хугацаа оруулах саналтай байна.</p> <p>Үүнд:</p>	Саналыг тусгасан.

		... Хэрэгжих явцад 3 сар үйл ажиллагаа алдагдалтай үргэлжилж байгаа.	
5.	Нийслэлийн Засаг дарга 2025.05.07 1/2894	<p>Хуулийн төсөлд Татварын Ерөнхий хуулийн 56 дугаар зүйлээр зохицуулсан Татварын давуу эрхийн зарчим, 57 дугаар зүйлээр зохицуулсан Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд, 58 дугаар зүйлийн дагуу Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өр хураах нийтлэг журамд заасан чиг үүргийг тусгуулах саналтай байна.</p> <p>Татвар төлөгчийг төлбөрийн чадваргүй болсон гэж тооцохоос өмнө Татварын Ерөнхий хуульд заасан татвар хураах, татварын өр барагдуулах чиг үүргийг хуулийн дагуу анхан болон дараагийн шатанд хэрэгжүүлдэг болно.</p>	Саналыг тусгасан.
		<p>14 дүгээр зүйл. Үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтийн хэлбэр, агуулга</p> <p>14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт заалтыг нэмэх: дараах "14.3.10. Үүрэг гүйцэтгэгч санхүүгийн тайланд тайлагнасан авлага, урьдчилж төлсөн зардлын гэх мэт эргэлтийн хөрөнгийн данс үлдэгдэлтэй тохиолдолд түүнтэй холбоотой баримт."</p> <p>Үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй гэдгийг нотлоход шаардлагатай бөгөөд хэрэв хөрөнгийн данс үлдэгдэлтэй байвал үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангахад зарцуулах тул мэдээллийг баримт авах шаардлагатай.</p>	Саналыг тусгаагүй.
		<p>22 дугаар зүйл. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх үндэслэл</p> <p>22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт дараах заалтыг нэмэх: "22.1.3.хяналтын байгууллагын мэргэшсэн шинжээчийн төлбөрийн чадваргүйдэлд орсон дүгнэлт гаргасан бол."</p> <p>Төрийн болон орон нутгийн Өмчит хуулийн этгээдийн хувьд ийм дүгнэлт шаардлагатай байдаг.</p>	Саналыг тусгаагүй. Хуулийн төсөлд тусгасан.
		24.9. Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангах төлбөрийн чадвартай нь илт байхад төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх хүсэлтийг үүрэг	Зарчмын хувьд тусгасан.

		<p>гүйцэтгэгч гаргасан эсхүл үүрэг гүйцэтгүүлэгчийн гаргасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх тухай хүсэлтэд хариу тайлбар гаргаагүйн улмаас төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлсэнтэй холбогдон бусад үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан хохирлыг үүрэг гүйцэтгэгч нөхөн төлнө.</p> <p>24.9. Нэхэмжлэлийн шаардлагыг хангах чадвартай бүрэн хангах төлбөрийн нь тогтоогдсон байхад төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх хүсэлтийг үүрэг гүйцэтгэгч гаргасан эсхүл үүрэг гүйцэтгүүлэгчийн ажиллагаа эхлүүлэх тухай хүсэлтэд хариу тайлбар гаргаагүйн улмаас төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлсэнтэй холбогдон бусад үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан хохирлыг үүрэг гүйцэтгэгчид нөхөн төлнө.</p> <p>Төлбөрийн чадвартай атлаа дампуурах хүсэлт гаргаж байгаа нь хариуцагчийг зохиомлоор дампуурах сонирхолтой байна гэж үзэх үндэслэл болохыг үгүйсгэх аргагүй юм.</p>	
6.	Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш П.Нямсүрэн	Хуулийн төслийн 28 дугаар зүйлд "Шүүх хэрэг гүйцэтгэгчийг энэ хуулийн 27.3-т заасан шүүхийн мэдээллийн цахим сангийн жагсаалтаас цахим хэлбэрээр, тохиолдлын журмаар сонгож томилно" гэснийг "...Шүүх хэрэг гүйцэтгэгчийг энэ хуулийн 27.3-т заасан шүүхийн мэдээллийн цахим сангийн жагсаалтаас цахим хэлбэрээр системээс санамсаргүй байдлаар тохиолдлоор сонгож, тэмдэглэл үйлдэн томилно.." гэж,	Саналыг тусгасан.
		II. Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.2.-т "Хэрэг гүйцэтгэгчээр шүүхээс томилсон тохиолдолд хуульд заасан үндэслэлээс бусад тохиолдлоор томилогдсон хэрэг гүйцэтгэгч татгалзахыг хориглоно" гэж,	Саналыг тусгаагүй.
		III. Хуулийн төслийн 70 дугаар зүйлд "...хариу төлбөргүйгээр..." гэсний дараа "...тухайн үеийн зах зээлийн үнээс хэт доогуур үнээр хариу төлбөртэйгээр..." гэж нэмж оруулах	Саналыг тусгаагүй. Саналын үндэслэл байхгүй.
		IV. Хуулийн төслийн 81 дүгээр зүйлд Барьцааны зүйлийг худалдах хэсэгт барьцааны эрх хэрэгжих боломжгүй нөхцөл байдал, барьцааны эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг зохицуулах оруулах гэсэн тус тус саналыг хүргүүлж байна.	Саналыг тусгаагүй. Саналын үндэслэл байхгүй.

7.	Улсын дээд шүүх 2025.05.09 1/1515	<p>1. Хуулийн төслийг "Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль" гэж нэрлэсэн байх боловч санал авахаар Улсын дээд шүүхэд ирүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1/1873 дугаарт албан бичиг, дагалдах баримтуудад төслийг "Дампуурлын тухай хууль" гэж нэрлэжээ. Өөрөөр хэлбэл, хууль санаачлагч төслийг санал авахаар хүргүүлэх үеийн байдлаар хоёр өөрөөр нэрлэсэн гэж үзэхээр байна. Хуулийн төслийг "Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль" нэрээр батлах нь хуулийн зорилго, зохицуулах зүйл, агуулга, мөн чанартай илүүтэй нийцнэ. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа нь үүрэг гүйцэтгэгчийг татан буулгах, дахин зохион байгуулах үндсэн хоёр ажиллагаанаас бүрдэх хэдий ч аль ч ажиллагааны эцсийн зорилго нь хуулийн этгээдийг дампууруулах бус, харин түүнтэй харилцагч, шаардах эрх бүхий бусад этгээдийн хөндөгдсөн эрх ашгийг шударгаар сэргээх, хөдөлмөрийн харилцаанд орсон ажилтан, зээл санхүүгийн харилцаанд орсон зээлдүүлэгч, бусад гэрээлэгчдийн бизнест таагүй үр дагавар учруулахгүйн тулд төлбөрийн чадваргүй болсон этгээдийн үйл ажиллагааг хэвийн болгоход чиглэгддэг онцлогтой. Өөрөөр хэлбэл, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа нь санхүүгийн чадавхгүй болсон этгээдэд "дампуурсан" гэх тодотгол өгч, богино хугацаанд зах зээлээс шахан зайлуулахад бус, харин санхүүгийн чадавхгүй болсон этгээдийн үйл ажиллагааг сахилга баттай, зөв, мэргэжлийн арга замаар дахин сэргээж, түүнтэй харилцагч, хөдөлмөр эрхлэгч бусад этгээдийн эрх ашгийг хамгаалахад чиглэх юм. Иймд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх болсон шалтгаан, үндэслэлийг анхаарч энэ харилцааг "төлбөрийн чадваргүйдлийн харилцаа" гэж нэрлэж занших нь хэлбэрийн бус агуулгын асуудал юм. Тус хуулийн үйлчлэлд хамрагдан санхүүгийн асуудлаа хугацаа алдалгүй шийдвэрлүүлэхээс зайлсхийдэггүй хандлагыг тогтооход хуулийн нэрийг зөв сонгох нь чухал ач холбогдолтой. Үгийн шууд утга, илэрхийлэл нь хуулийн талаарх сөрөг ойлголтыг түгээх, үйлчлэлээс зугтах, зохицуулалтын хүрээнд хамрагдахгүй байхыг хичээхэд нөлөөлөх тул "дампуурал" гэх нэр томъёог хэрэглэхээс зайлсхийх нь зүйтэй.</p>	Саналыг тусгасан.
		<p>2. Төслийн 5 дугаар зүйлд төлбөрийн чадваргүйдлийн харилцааны "хэргийн оролцогч" гэх ойлголтыг тодорхойлсон байна. Тус нэр томъёоны ач холбогдол, үр дагавар төслийн 34 дүгээр зүйлийн 34.1, 37 дугаар зүйлийн 37.4 зэрэг хэд хэдэн зүйл, заалтуудаас гадна мөн 5 дугаар зүйлийн 5.2 дах хэсэгт нууц</p>	Саналыг тусгаагүй.



		<p>хадгалах үүргийг хэргийн оролцогчид хүлээлгэсэн байдлаар илэрч байна. Хэргийн оролцогчид "түр хэрэг гүйцэтгэгч" болон ажиллагаанд оролцож болох бусад этгээд (хэрэг гүйцэтгэгчийн томилсон шинжээч, бүтцийн өөрчлөлтийн ажиллагаан дахь бусад оролцогч г.м) хамаарахгүй байгаа шалтгааныг анхаарч, томьёоллын хүрээг дахин авч үзэхийг санал болгож байна. Өөрөөр хэлбэл, хэргийн оролцогч гэх ойлголтыг ийнхүү хумьсан нь тодорхой шалтгаан (хэргийн оролцогчид учирсан хохирлыг хэрэг гүйцэтгэгч хариуцах г.м)-тай эсэх, эсхүл тодорхой тохиолдолд, жишээлбэл нууц хадгалах зэрэг тохиолдлуудад ялгаатай байх боломжтой эсэхийг анхаарах нь зүйтэй байна.</p>	
		<p>3. Төслийн 20.2-т түр хэрэг гүйцэтгэгч нь үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй бөгөөд түүний хөрөнгө төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа /ТЧА/-ны зардлыг хариуцах боломжгүй гэсэн дүгнэлт гаргавал ТЧА-ны урьдчилсан төлбөрийг аль нэг үүрэг гүйцэтгүүлэгч, эсхүл сонирхогч этгээд төлөхөөр зохицуулсан нь логикийн алдаатай болжээ. Тодруулбал, ТЧА эхлүүлэх хүсэлтийг хүлээн авсан шүүх 10 хоногт бүрдүүлбэрийг хянаж, хүсэлтийг татгалзах үндэслэлгүй гэж үзвэл урьдчилсан төлбөр төлөхийг хүсэлт гаргагчид даалгах, хүсэлт гаргагч 7 хоногт уг төлбөрийг төлөхөөр төсөлд зохицуулсан. Улмаар урьдчилсан төлбөр төлөгдсөн бол шүүх 7 хоногт түр хэрэг гүйцэтгэгчийг томилж, түр хэрэг гүйцэтгэгч ийнхүү томилогдсоноос хойш 20 хоногт төлбөрийн чадвартай эсэх, ажиллагааны зардлыг хариуцах Боломжтой эсэх талаар дүгнэлт гаргахаар байна. Түр хэрэг гүйцэтгэгч нь үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй бөгөөд ажиллагааны зардлаа хариуцах боломжтой -эх дүгнэлт гаргасан бол шүүх 5 хоногийн дотор ТЧА эхлүүлэх захирамж /төслийн 24.1/ гаргаж байна. Эндээс дүгнэвэл шүүх ТЧА эхлүүлэх захирамж гаргах үед урьдчилсан төлбөр нэгэнт төлөгдчихсөн байна гэж таамаглахаар байна. Иймд Эслийн 20.2-т зааснаар түр хэрэг гүйцэтгэгч дүгнэлт гаргах үед урьдчилсан төлбөрийг дахин өөр этгээдээр төлүүлэх нөхцөл үүсэхгүй тул төслийн 20.2-т заасан</p> <p>аль нэг үүрэг гүйцэтгүүлэгч, эсхүл сонирхогч этгээдийн хариуцах төлбөр нь урьдчилсан төлбөр бус, харин ТЧА-ны зардал байх магадлалтай.</p>	Саналыг тусгаагүй.
		<p>4. Төслийн 22 дугаар зүйл энэ хуулийн хэрэгжилтэд нэн чухал ач холбогдолтой. ТЧА-г эхлүүлснээр үүрэг гүйцэтгэгчийн хувийн, эдийн засгийн эрх ашиг</p>	

	<p>хөндөгдөх үндэслэл бүрдэх юм. ТЧА зорьсон зорилгодоо хүрэхийн тулд энэ нөхцөл байдлыг хуулиар зөвшөөрөх нь зарим улс орны Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль, холбогдох судалгааны материалуудаас илэрхий байна. Иймд бусдын эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж, бизнесийн харилцаанд бие даан шийдвэр гаргах эрх ашгийг хөндөх эрх зүйн үндэслэлийг сайтар судалж тогтоовол зохино. Төслийн 22 дугаар зүйлд хоёр үндэслэл тогтоосон байх ба үүний нэгдүгээрх нь үүрэг гүйцэтгүүлэгч буюу шаардах эрх бүхий этгээд шууд таамаглах боломжтой шалгуур болох хууль, гэрээнд заасан үүргээ үргэлжилсэн 6 сарын хугацаанд биелүүлэхгүй байх нөхцөлийг тусгажээ. Энэ үндэслэлийг цөөнгүй улсууд хуульчилсан байна. Гэвч ихэвчлэн бэлэн мөнгөний урсгал саатсанаар илрэх энэ үзэгдлийн шалтгаан нь түр зуурын санхүүгийн хүндрэл байх нь олонтаа. Иймд зарим улс оронд энэ стандартыг өрсөлдөгч бизнес эрхлэгчээ түр хугацаанд "дуугүй байлгах" арга хэрэгсэл болгон гуйвуулж хэрэглэхээс урьдчилан сэргийлж төлбөрийн чадваргүй байдлыг балансын аргаар тогтоодог хувилбарыг сонгох нь бий.</p> <p>Нөгөө талаас төслийн 22.1.2-т төлбөрийн чадваргүйдлийг тодорхойлох балансын аргыг хэрэглэсэн байна. Энэ үндэслэлийг мэргэшсэн нягтлан бодогч, аудитор, түүнчлэн бизнесийн сектор тус бүрийн саналыг сонсож томъёолохыг санал болгож байна. Санхүүгийн тайланг уншихад хуулийн этгээдийн төлбөрийн чадварыг илтгэх хэд хэдэн чухал харьцаа байдаг нь сектор тус бүрээс хамаарч ялгаатай дүгнэлтэд хүргэдэг. Жишээлбэл, капиталжилтын харьцаа буюу урт хугацааны өр төлбөрт урт хугацаат өр төлбөр ба эзний өмчийн нийлбэр нь 50 хувийн харьцаатай байх нь цахилгаан, эрчим хүчний компаниудад асуудал биш гэж мэргэжилтнүүд үздэг бол бусад салбарт энэ өр төлбөр 50 хувьд хүрэхийг өндөр эрсдэлтэй гэж үздэг. Гэтэл төслийн томъёоллоор урт хугацааны өр төлбөр бус, нийт өр төлбөрийн нийт хөрөнгө дэх харьцаагаар тогтоосон нь төдийлөн санхүүгийн хүндрэлтэй бус хуулийн этгээдийг ч төлбөрийн чадваргүй гэж үзэхэд хүргэх сөрөг талтай байж болох юм.</p> <p>Иймд энэ хэсгийг сайтар судалж, аудит, нягтлан бодох бүртгэл, хууль зүйн мэргэжилтнүүдтэй хэлэлцсэний үндсэн дээр нухацтай хандахыг санал болгож байна.</p>	Саналыг тусгасан.
--	---	-------------------

		5. Төслийн 58 дугаар зүйл нь ТЧА-ны явцад тухайн үүрэг гүйцэтгэгчтэй холбоотой үүссэн шийдвэр гүйцэтгэлийн бусад ажиллагааг дангаар, хувьчлан гүйцэтгэхгүй байхыг илтгэсэн зохицуулалт тул нэрийг "Шийдвэрийг албадан гүйцэтгэхгүй байх" гэх байдлаар тусгаж өгөх нь зүйтэй.	Саналыг тусгасан.
		6. Төсөлд 60 дугаар зүйлийн нэр нь агуулгатайгаа тохирохгүй байгаагийн зэрэгцээ 61 дүгээр зүйл үгүй байна. Магадгүй 61 дүгээр зүйлийн агуулгад 60 дугаар зүйлийн нэрийг өгч, 60 дугаар зүйлийн агуулгыг 61 дүгээр зүйлийн нэрийн хамт орхисон, эсхүл арилгасан байх боломжтой алдаа гарчээ. Энэ нь техникийн алдаа мэт боловч агуулгын ноцтой үр дагавартайг дурдаж байна.	Саналыг тусгасан.
		7. Төслийн 77 дугаар зүйлийн 77.1-д заасан судалгаа нь үүрэг гүйцэтгүүлэгчдийн хувьд нэн чухал судалгаанд тооцогдоно. Энэ судалгаанд тулгуурлан үүрэг гүйцэтгэгчийг дахин санхүүжүүлэх эсэх, эсхүл байгаа хөрөнгийг худалдан борлуулж, холбогдох шаардлагаа хангуулан татан буулгах эсэх шийдвэрийг үүрэг гүйцэтгүүлэгч гаргах тул тус судалгаа дүгнэлтийн хурлаас өмнө бэлэн болох нь чухал. Гэвч тус судалгааг хэрэг гүйцэтгэгч ТЧА эхлүүлснээс хойш 56 хоногийн дотор гаргана гэсэн нь харьцангуй урт хугацаа гэж үзэхээр байна. Өмнө дурдсанчлан шүүх ТЧА эхлүүлэх хүртэл төсөлд дурдсан тодорхой хугацааны дээд хязгаараар, улмаар холбогдох захирамжуудад тухайн шатандаа гомдол гаргаагүй, мөн төлбөрийн чадваргүйдлийн шалтгааныг тодруулах хурал хийгээгүй гэж тооцвол 46 хоног (10+7+7+20+5)-ийн процесс үргэлжилж байна. Ийнхүү ажиллагаа эхлүүлснээс хойш 14-60 хоногийн дотор нэхэмжлэлийг хүлээн авч, нэхэмжлэл авч дууссанаас хойш 20 хоногт баталгаажуулах хурал хийхээр байх ба дүгнэлтийн хурал хамгийн шуурхай хийгдэх боломжит хугацаа нь баталгаажуулах хуралтай хамт хийгдэхээр байна. Иймд хэрэг гүйцэтгэгч хуваарилагдах хөрөнгө ба шаардлагын харьцааг тодорхойлсон тус судалгаа гаргах хугацааг ТЧА эхлүүлсэн өдрөөс бус нэхэмжлэлийг хүлээн авч дууссан өдрөөс тоолж, хамгийн боломжит богино хугацаагаар тогтоох нь зүйтэй.	Саналыг тусгасан.
		8. Төслийн 9 дүгээр бүлгийн хуваарилалтын ажиллагаа хэсэгт зарим нэр томъёог жигдрүүлэх шаардлагатай. Тухайлбал төслийн 84.1, 84.3, 86 дугаар зүйлийн нэрүүдэд туссан "хуваарилагдах хөрөнгө" гэх нэр томъёо нь угтаа хуваарилагдах хөрөнгийг худалдан борлуулж, мөнгөн хөрөнгө болгосныг хэлэх юм. Өөрөөр хэлбэл, ТЧА-ны "хуваарилагдах хөрөнгө", "хуваарилагдах мөнгөн хөрөнгө" гэх ойлголтууд нь ялгаатай тул эдгээрийг анхаарч нэг мөр болгох шаардлагатай	Саналыг тусгасан.

		<p>байна. ТЧА-ны явцад хуваарилагдах хөрөнгө нь үүрэг гүйцэтгэгчийн биет болон биет бус, хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгө байх ба энэ хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчдэд шууд тараах, хуваарилах харилцаа байх боломжгүй, харин эдгээр хөрөнгийг худалдан борлуулж мөнгөн хөрөнгө (liquid) болгосныг үүрэг гүйцэтгүүлэгч нарт хуваарилах юм. Иймд төслийн 84.1, 84.3, 86 дугаар зүйлд туссан "хуваарилагдах хөрөнгө" гэсэн нэр томьёо нь жинхэнэ утгаараа "хуваарилагдах хөрөнгө" бус "хуваарилагдах мөнгөн хөрөнгө"-ийг илэрхийлэх юм. Түүнчлэн төслийн 86 дугаар зүйлийн 86.2, 86.3, 86.6-д заасан "хуваарилалтын ажиллагааны хөрөнгө" гэж дээр дурдсан мөнгөн хөрөнгийг өөр нэр томьёогоор нэрлэсэн байх тул эдгээр томьёоллыг энэ бүлэгт, шаардлагатай бол төсөлд бүхэлд нь жигдлэх нь зүйтэй.</p>	
		<p>9. Төсөлд үүрэг гүйцэтгэгчийн хуваарилагдах хөрөнгийг худалдах, мөнгөн хөрөнгийг хуваарилах ажиллагааг хэрэг гүйцэтгэгч эхлүүлэхэд тавигдах хэлбэрийн шаардлагыг нэлээд төвөгтэй зохицуулсан гэж үзэхээр байна. Гэтэл энэ нь ТЧА-ны хамгийн чухал ажилбаруудын нэг. Иймд энэ талаар хууль тогтоогч ямар шаардлага, шалгуур тавьж байгаагаа хоёрдмол утгагүй тодорхой илэрхийлэх нь зүйтэй байна.</p> <p>Энэ асуудлыг зохицуулсан тухайлсан бүлэг болох наймдугаар бүлэгт хуваарилагдах хөрөнгийг худалдаж эхлэхдээ хэрэг гүйцэтгэгч шүүх, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурал, эсхүл зөвлөлийн зөвшөөрлийг авсан байх тодорхой шаардлага үгүй байгаа. Гэвч төслийн 79.1-д үүрэг гүйцэтгүүлэгчдийн дүгнэлтийн хурлаас өөрөөр шийдвэрлээгүй бол хэрэг гүйцэтгэгч хөрөнгийг шууд худалдаж эхлэхээр заасныг хэрхэн ойлгохоос ийм шаардлага үйлчилж буй эсэхийг тогтооно гэж үзэхээр байна. Тодруулбал, төслийн 51 дүгээр зүйлд дүгнэлтийн хурлаар хэлэлцэх асуудлыг тусгасан байх ба 51.3-т үүрэг гүйцэтгэгчийг татан буулгах, эсхүл дахин зохион байгуулах эсэхийг шийдвэрлэхээр заажээ. Үүнээс үзвэл төслийн 79.1-д заасан дүгнэлтийн хурлын шийдвэр нь шууд утгаараа хуваарилагдах хөрөнгийг худалдах, эс худалдах асуудал гэхээс илүүтэй үүрэг гүйцэтгэгчийг татан буулгах, эсхүл дахин зохион байгуулах эсэх тухай асуудал гэж үзнэ. Иймд төслийн 79.1 дэх хэсгээр хөрөнгө худалдах ажиллагааны талаар үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурал зөвшөөрөл өгөх асуудлыг зохицуулаагүй гэж ойлгох магадлал өндөр. Энэ шаардлагыг тодорхой болгох нь зүйтэй.</p>	Зарчмын хувьд саналыг тусгасан.

		<p>Харин төслийн 80.1-д хуваарилагдах хөрөнгө нь үйлдвэрийн газар, байгууламж бөгөөд эдгээрийг бүхэлд нь худалдах бол үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурал/зөвлөлөөс зөвшөөрөл авахаар заасан байна. Эндээс хуваарилагдах хөрөнгийг худалдах ажиллагааг эхлүүлэхдээ 80.1-д заасан бүхлээр нь худалдахаас бусад тохиолдолд хэн нэгний зөвшөөрөл, баталгааг шаардахгүй гэж ойлгохоор байна.</p> <p>Нөгөө талаас хэрэг гүйцэтгэгчийн бүрэн эрхэд зарим төлөвлөгөөг хэрэг гүйцэтгэгч боловсруулж үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлаар батлуулахаар заасан нь зөрчил үүсгэхээр харагдаж байна. Тодруулбал, төслийн 26.1.6-д хэрэг гүйцэтгэгч нь хөрөнгө хуваарилах, захиран зарцуулах төлөвлөгөө боловсруулан үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлаар батлуулах бүрэн эрхтэй гэж заасан боловч энэ ажиллагааг хэзээ, ямар үед хийх процесс тодорхойгүй болжээ. Төслийн 26.1.7-д нэхэмжлэлийн шаардлагыг төлөвлөгөөний дагуу хангахаар зааснаас үзвэл уг заалт дахь төлөвлөгөө нь төслийн 26.1.6-д заасан төлөвлөгөөнөөс ялгаатай байна. Төслийн 26.1.6-д худалдах ажиллагааны төлөвлөгөөг, 26.1.7-д хуваарилах ажиллагааны төлөвлөгөөг тусгасан гэж үзвэл эдгээр төлөвлөгөөг хэзээ, ямар хурлаар хэрхэн батлуулах процессыг бий болгох шаардлага байгааг анхаарч төслийг сайжруулах нь зөв байна.</p>	
		<p>10. Хуваарилагдах хөрөнгийг худалдаж, бий болсон мөнгөн хөрөнгийг хуваарилах ажиллагааг эхлүүлэхдээ хэрэг гүйцэтгэгч төлөвлөгөө боловсруулсан байх агуулга төслийн 26.1.7-д туссан байна. Гэтэл төслийн 83.1-д хуваарилах ажиллагааг дүгнэлтийн хурлын дараа шүүхийн зөвшөөрлөөр шууд эхлүүлэхээр заажээ. Түүнчлэн 83.5-д хуваарилалт бүрийн өмнө үүрэг гүйцэтгүүлэгчдийн зөвлөлөөс, зөвлөлгүй бол шүүхээс зөвшөөрөл авахаар заасан байна. Хуваарилах ажиллагаа эхэлсэн бол хэсэгчилсэн, сүүлчийн, нэмэлт хуваарилалтууд хийгдэж байгаагаас үзвэл "хуваарилах ажиллагааг эхлүүлэх", "хуваарилалт хийх" ойлголтууд ялгаатай байна. Иймд төслийн 83.1, 83.5 дахь хэсгүүд өөр өөр зөвшөөрлийн талаар зохицуулсан гэж үзэхээр байна. Эндээс төслийн 26.1.7-д заасан төлөвлөгөөг хэрхэн шүүхийн болон үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөлтэй уялдуулах талаар ажлын хэсэг сайтар ярилцах шаардлагатай. Төслийн 26.1.7 дэх хэсгийн заалт одоогийн хүчин төгөлдөр</p>	Саналыг тусгасан.

		Дампуурлын тухай хуулийн зохицуулалттай адил байх бөгөөд энэ зохицуулалтыг хэвээр үлдээхдээ шинэ зохицуулалттай уялдуулаагүй байх магадлалтай байгааг анхаарах шаардлагатай.	
		11. Төслийн 87.1-д заасан "хуваарилалтын ажиллагааны талаарх мэдээ" нь 83.5-д заасан зөвшөөрөл авах процесс болон 26.1.7-д заасан төлөвлөгөөтэй хэрхэн уялдаж байгааг анхаарч төслийг сайжруулах шаардлагатай байна. Төслийн 87, 88, 89 дүгээр зүйлд заасан "хуваарилалтын ажиллагааны талаарх мэдээ" нь хуваарилах ажиллагааны тухай мэдээ биш, "хэсэгчилсэн хуваарилалт хийх төсөл" байх агуулгатай байна. Төслийн энэ бүлэгт "хуваарилах ажиллагаа", "хуваарилалт", "хэсэгчилсэн хуваарилалт", "сүүлчийн хуваарилалт", "нэмэлт хуваарилалт" гэх үндсэн концепци байх ёстойг анхаарч, нэр томьёог зөв, оновчтой хэрэглэх нь зүйтэй.	Саналыг тусгаагүй.
		<p>12. Төсөлд ТЧА нь татан буулгах ажиллагаагаар үргэлжлэх үед дараах үндэслэлүүдээр ажиллагаа дуусаж байна. Үүнд:</p> <p>Төслийн 93.1-д заасны дагуу эцсийн хуваарилалт хийснээр ТЧА дуусгавар болж байна. Гэхдээ нэмэлт хөрөнгө илэрвэл ажиллагааг хариуцах хэрэг гүйцэтгэгчийн үүрэг хэвээр үлдэнэ. Энэ тохиолдолд төслийн томьёоллоос үзвэл шүүх Монгол Улсын нэрийн өмнөөс шүүхийн шийдвэр гаргана гэж үзэхээр байна. Гэвч энэ шийдвэрт хэрхэн давж заалдах гомдол гаргах нь тодорхойгүй байгаагаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн ерөнхий зарчим үйлчилнэ. Гэвч ТЧА-ны тохиолдолд хэргийн оролцогчийн бүрэлдэхүүн өөр тул тусгайлсан зохицуулалт шаардлагатай.</p> <p>Төсөлд зааснаар ТЧА зогсох замаар дуусаж болох бөгөөд энэ нь дараах 3 үндэслэл байна. Үүнд:</p> <p>Хуваарилагдах хөрөнгө нь ТЧА-ны зардлыг хариуцахад хүрэлцэхгүй болох нь тогтоогдох</p> <p>ТЧА-г эхлүүлэх үндэслэлгүй байсан нь тогтоогдох</p> <p>Бүх үүрэг гүйцэтгүүлэгчид зөвшөөрснөөр ТЧА зогсох</p>	Зарчмын хувьд саналыг тусгасан.

		<p>Дээрх 3 тохиолдлоос сүүлийн 2 тохиолдолд шүүгч захирамж гаргаж, хэргийг хэрэгсэхгүй болгохоор заасан бол эхний тохиолдолд ямар эрхийн акт гарах зохицуулалт тодорхойгүй байна.</p> <p>Төслийн 100.3-т зааснаас үзвэл тухайн шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны захирамж гэж ойлгохоор байна. Энэ тохиолдлуудад давж заалдах журмаар гомдол гаргахгүй гэж ойлгохоор байна. Гэвч энэ зохицуулалт тодорхойгүй байгааг тодруулах, сайжруулах шаардлагатай.</p>	
		<p>13. Төсөлд ТЧА дахин зохион байгуулах ажиллагаагаар үргэлжлэх үед дараах үндэслэлээр дуусгавар болохоор байна. Үүнд:</p> <p>Дахин зохион байгуулах төлөвлөгөө амжилтгүй болж татан буулгах ажиллагаанд шилжих- Энэ тохиолдолд шүүх ямар эрхийн акт гаргах нь мөн л төсөлд тодорхойгүй байна.</p> <p>Төслийн 118.2-т зааснаар үүрэг гүйцэтгүүлэгчдийн шаардлагыг татан буулгах ажиллагааны журмаар хангахыг хэрэг гүйцэтгэгчид шүүх даалгах бөгөөд ийнхүү даалгах буюу дахин зохион байгуулах ажиллагаанаас татан буулгалтын ажиллагаанд шилжихдээ гаргах эрхийн акт, түүнд гомдол гаргах эсэх харилцааг зохицуулж, тодорхой болгох шаардлагатай.</p>	Саналыг тусгасан.
		<p>13. Дахин зохион байгуулах ажиллагаа үндсэндээ зорилгоо биелүүлэх хоёр тохиолдол байж болохоор төсөлд заасан. Үүнд, нэгдүгээрт, төлөвлөгөө биелж, зорилгодоо хүрснээр дуусгавар болох тохиолдол хамаарах бөгөөд энэ тохиолдолд шүүх ТЧА дуусгавар болгож, хэргийг хэрэгсэхгүй болгохоор заасан байна. Хэргийг хэрэгсэхгүй болгож байгаагаас үзвэл шүүгч захирамж гаргах, түүнд давж заалдах журмаар гомдол гаргахгүй байх нийтлэг практик байдаг боловч энэ нь тус тохиолдолд үйлчлэх эсэхийг тодорхой заавал зохино. Хоёрдугаарт, төлөвлөгөө хэрэгжиж дуусаагүй ч бүх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж дууссанаар ТЧА дуусгавар болж болохоор төслийн 117.1.3-т заасан. Энэ</p>	Саналыг тусгасан.

		үед мөн л хэргийг хэрэгсэхгүй болгож байх бөгөөд шүүхээс гарах эрхийн актыг, гомдол гаргах эрх байх эсэх талаар тодорхой зохицуулалт шаардлагатай.	
		14.Төслийн 143 дугаар зүйлд бүтцийн өөрчлөлтийн ажиллагааны дуусгавар болгох үндэслэлийн талаар зохицуулсан боловч энэ талаар шүүхээс гарах эрхийн акт, бусад шаардлагатай процессыг орхигдуулсан байгааг нэмж тусгах нь зүйтэй.	Саналыг тусгасан.
		<p>15.Тус төсөл нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг хөгжингүй гадаад улсын зохицуулалтын өнөөгийн байдалтай нийцүүлэн төрөлжүүлэх алхмыг хууль санаачлагч баримталж байгааг илтгэж байна. Тодруулбал, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн орчин тодорхой нэг этгээд, эсхүл цөөн тооны бүлэг этгээдийн эрх ашиг зөрчигдсөнтэй холбоотой хувийн эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд чиглэсэн ердийн ажиллагаанд тохирсон бөгөөд манай улсад иргэний эрх зүйн хамтын маргаан (төлбөрийн чадваргүйдлийн маргаан, бүлгийн нэхэмжлэлээр үүсэх маргаан г.м)-ыг шийдэхэд чиглэсэн эрх зүйн орчин нэн дутмаг байгаа. Энэ агуулгаараа тус хуулийн төсөл нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн салбарт зохицуулалтын болон ойлголтын шинэтгэл бий болгоно.</p> <p>Иймд төсөл батлагдан хууль болж үйлчлэхээс өмнө иргэний хэргийн шүүх, шүүхийн захиргаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд хүний нөөц, мэргэшил, зохион байгуулалт, дэд бүтцийн бэлтгэл хангах шаардлага үүсэхээр байна. Өнөөдөр үйлчилж байгаа Дампуурлын тухай хууль нь хэт ерөнхий, нарийвчилсан бус зохицуулалттай байсныг төсөл залруулж, цогц, нарийн мэргэшсэн шинжтэй болгосон байх тул төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны эрх зүйн зохицуулалтын энэ өөрчлөлтийн талаар шүүгч нарт ойлгуулан таниулах, мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэх, төсөлд тусгагдсан шүүхийн мэдээллийн сан Гажиллагааны талаар нийтэд мэдээлэх, хэрэг гүйцэтгэгчийн нөөц бий болгох зорилго Бүхий)-г бүтээх, шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд тохирсон хэргийн сөдөлгөөний цахим программ бий болгох (өнөөдөр улсын хэмжээнд хэрэглэж байгаа эрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим систем төлбөрийн чадваргүйдлийн жиллагаанд тохирохгүй) шаардлага үүсэж байна. Иймд тус төслийг бодитой эрэгжүүлэхэд шүүхэд хүний нөөц,</p>	Саналыг тусгасан.



		санхүү, дэд бүтцийн цогц бэлтгэл шаардлагатайг нхаарч хууль хүчин төгөлдөр болох хугацааг үндэслэлтэйгээр тодорхойлох хэрэгтэй байна.	
		<p>16. Тус хуулийн төслийг дагалдан бусад хуулиудад нэмэлт өөрчлөлт орохдоо агуулгын бус нэр томъёоны өөрчлөлт зонхилж байгааг анхаарвал зохино. Жишээлбэл, бусад хуулиудад "төлбөрийн чадваргүйд тооцсон" гэх хууль зүйн үйлдэл, үе агшныг өөр бусад ажиллагаа эхлүүлэх, үр дагавар үүсгэх үндэслэл болгож байгаа нь буруу байна. Учир нь хуулийн төсөлд "төлбөрийн чадваргүйд тооцох" гэх ойлголт зохицуулагдаагүй, харин "төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргах", "түр хэрэг гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй талаар дүгнэлт гаргах", "төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх" гэх ойлголтууд байгааг анхаарч, тохирсон үр дагавар бүхий үйлдлийг сонгож, нэмэлт, өөрчлөлтөд тусгавал зохино. Шинэчилсэн найруулгын хуулийн тус төсөл нь өдгөө үйлчилж байгаа Дампуурлын тухай хуулиас өргөн хүрээтэй, нарийвчилсан зохицуулалт бүхий хууль байх тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад агуулгын өөрчлөлт орох үндэслэлтэйг анхаарвал зохино.</p> <p>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд хоёр санхүүгийн жил санхүү, татварын тайлангаа гаргаагүй хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах өөрчлөлтийг тусгасан байх бөгөөд ийнхүү хасахгүй байх үндэслэлүүдэд "бичгээр санал гомдол гарах", "төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх", "санхүүгийн тайлангаа илгээх", "шүүхийн шийдвэрээр тогтоосон өр төлбөртэй нь тогтоогдох", "татварын өр үүсэх", нөхцөлүүдийг тусгажээ. Энэ харилцаа энэ мэт ерөнхий, ойлгомж муутай жагсаалтын хүрээнд бүрэн зохицуулагдахгүй. Энд заасан үндэслэл тус бүр нарийвчилсан процесс шаардах бөгөөд аль болох гүйцэд, боловсронгуй байвал зохино. Зарим талаар энэ үндэслэлүүд өөр хоорондоо зөрчилтэй байх ч боломжтой байна.</p> <p>Өнөөдөр шүүхийн практикт дампуурлын ажиллагаа эхлүүлсэн хуулийн этгээдийн нэлээдгүй хувь нь санхүү, татварын тайлангаа 2 жил ба түүнээс дээш хугацаанд гаргаагүй, тусгайлсан хөрөнгөгүй, үйл ажиллагаа эрхлэхээ зогсоосон</p>	Саналыг тусгасан.

		<p>хуулийн этгээд байна. Энэ ч утгаараа дампуурлын ажиллагаа гэдгийг хуульч, бусад мэргэжлийн этгээдийн хүрээнд үйл ажиллагаа явуулахгүй байгаа, идэвхгүй болоод удсан хуулийн этгээдэд нэр төдий хэрэгжүүлдэг ажиллагаа гэж ойлгох хандлага тогтжээ. Гэвч энэ нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны мөн чанарт нийцэхгүй, хуулийн этгээдийг татан буулгах өөр үндэслэлд хамаарах юм. Энэ талаар бие даасан хууль шаардлагатай бөгөөд ийм төрлийн хуулиар удаан хугацаанд идэвхгүй байгаа, хөрөнгө мөнгөгүй хуулийн этгээдийг татан буулгах ажиллагааны зардлыг хариуцах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх нь нэн чухал. Энэ асуудлыг шийдвэрлэхгүйгээр ерөнхий агуулга бүхий хуулийн өөрчлөлт хангалтгүй, хуулийн зохицуулалт шаардлагатай нийгмийн хэрэгцээ хариултгүй хэвээр үлдэнэ.</p> <p>Иймд энэ чиглэлээр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд оруулах өөрчлөлтийг цогц, хангалттай процессжуулан тусгахыг санал болгож байна.</p>	
8.	Баянүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх 2025.05.12 4821	<p>1.Санаатай дампуурал нь ихэвчлэн компани идэвхтэй үйл ажиллагаа явуулж байх үедээ бага багаар хөрөнгөө хувь хүн хуулийн этгээдэд шилжүүлэх байдлаар хөрөнгөгүй болж, сүүлийн 5-10 жил "Х" тайлан гаргаж дампууруулдаг. Хэрэг гүйцэтгэгч нь хөрөнгө шилжсэн гуравдагч этгээд болох хувь хүн, хуулийн этгээдэд орсон хөрөнгийг шалгах эрх байдаггүй, бас ямар зориулалтаар яагаад шилжүүлснийг тогтоож чаддаггүй. Иймээс хэрэг гүйцэтгэгчийн гуравдагч этгээдэд шилжсэн хөрөнгийг шалгаж тогтоох, эд хөрөнгийг буцаан гаргуулах талаар нэхэмжлэл гаргах эрхийг илүү тодорхой үндэслэл, процесстой нь зохицуулах.</p> <p>Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад санаатай, гэмт хэргийн шинжтэй үйлдэл илэрвэл шүүхээс прокурорыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулж, гэмт хэргийн санаатай үйлдлийг шалгуулдаг байх, эсхүл прокурорын байгууллагад шилжүүлдэг байж болохоор зохицуулах.</p>	ХЭУБТХ-иар Х тайлан өгч байгаа бол Улсын бүртгэлд хандан татан буулгадаг.
		2.Компанийг дампууруулсан хуулийн этгээдийн удирдлагын талаар болон шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлийн байгууллагаас хасах талаарх улсын бүртгэлийн зохицуулалтыг тодорхой болгох,	Саналыг тусгасан.

		<p>3. Үүрэг гүйцэтгүүлэгч илүүтэйгээр дампууруулах хүсэлт гаргах эрхтэй байх тул нийтэд зарлах мэдээллийг тодорхой давтамжтай байлгах.</p> <p>Хуулийн зохицуулалтаас нийтэд мэдээлэх нь нэг удаагийн шинжтэй байхаар харагдаж байх ба энэ нь өнөөдрийн шүүхийн практикт хэрэгжиж байгаатай адил, үр дүн муутай, нийтэд түгэх хүрээ бага байдаг. /9 дүгээр зүйл/</p>	Саналыг тусгасан.
		<p>4. Шүүх хаанаас, хэнээс, хэдэн жилийн хугацаатай ямар лавлагаа авах зэргийг хуульд журамлах. Ихэвчлэн шүүгч өөрсдийн санаачилгаар л лавлагаануудаа авдаг. Үүнээс болоод зарим ажиллагаа дутуу явагдах, хөрөнгө мөнгө нь илрэхгүй үлдэх асуудал мөн үүсдэг байж магадгүй юм.</p>	Саналыг тусгаагүй.
		<p>5. Хуулийн төслийн 4.1.12-т "доод эрэмбийн шаардлага" гэж байгаа, ямар үнийн дүнтэйг хэлэх юм бол гэдэг нь тодорхойгүй, 40.1-д зааснаар тодорхойлогдож чадаж байна уу гэдгийг эргэн харах, 6.2-т заасан "эрх бүхий албан тушаалтан", 12.2, 20.4-т заасан "гүйцэтгэх удирдлага" гэдэгт хэнийг ойлгох нь тодорхойгүй, Компанийн тухай хуулийн 83, 84 дүгээр зүйлд заасан этгээд гэж шууд зохицуулах боломжтой эсэх,</p>	Саналыг тусгаагүй. Компанийн тухай хууль үйлчилнэ.
		<p>6. Хуулийн төслийн 20.1 дэх заалт төлбөрийн чадваргүйд тооцуулах зорилгодоо нийцэхгүй харагдаж байх ба "төлбөрийн чадваргүй" гэдгийг "төлбөрийн чадвартай" гэж ойлгох уу, агуулга ойлгомжгүй.</p>	Саналыг тусгаагүй. Хуулийн төсөлд тодорхой тусгасан.
		<p>7. Хуулийн төслийн 32.1-д зааснаар хэрэг гүйцэтгэгчийн ажлын хөлсний хэмжээг шүүх тогтоох зохицуулалт ойлгомжгүй. Шүүх талуудын санхүүгийн асуудалд хөндлөнгөөс оролцох нь зохимжгүй байх тул хэрэг гүйцэтгэгч нь үүрэг гүйцэтгүүлэгчдийн хуралтай тохиролцож тогтоохоор зохицуулалтыг өөрчлөх боломжтой байна.</p>	Саналыг тусгаагүй. Олон улсын жишигт нийцүүлсэн.
		<p>8. Хуулийн төслийн 33.3-т заасан боломжит хугацаа гэдэг нь хэд хоног вэ, тодорхойгүй байгаа учраас хугацааг тодорхой болгон зохицуулах,</p>	Саналыг тусгасан.
		<p>9. Хуулийн төслийн 47.4 ойлгомжгүй, ... гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ гэхлээр зэрэгцээд нэхэмжлэл гаргаад явах юм уу, эсхүл ажиллагааны явцад үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэр буюу эрхийн актад нь тухайн шүүхэд гомдол гаргах хэлбэрээр зохицуулах юм уу, ер нь үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлаас гарч байгаа шийдвэр ямар хэлбэртэй байх вэ,</p>	Саналыг тусгаагүй. Хуулийн төсөлд тодорхой тусгасан.
		<p>10. Хуулийн төслийн 60.1.1 дэх заалт ойлгомжгүй,</p>	Саналыг тусгаагүй.

			Хуулийн төсөлд тодорхой тусгасан.
		11. Хуулийн төслийн 83.1, 83.5, 90.1, 92.1 гэх мэт заалтуудад зааснаар ажиллагаанд "шүүхийн зөвшөөрөл" ямар хэлбэртэй байх нь тодорхойгүй, зөвшөөрөл олгох хугацаа тодорхойгүй. Харин үүнийг 90.3-т заасантай харьцуулж харвал зөвшөөрсөн шүүгчийн захирамж гарахаар байна. Тиймээс дурдсан зохицуулалтуудад "шүүгчийн захирамж" болон хугацааны зохицуулалтыг нэмж тусгах,	Саналыг тусгаагүй. Хуулийн төслийн 85.5-д тухай бүр гэсэн.
		12.Хуулийн төслийн 99.3-т заасан "шүүхэд хандаж болно" гэдгийг "шүүхэд гомдол гаргаж болно" гэж өөрчлөх,	Саналыг тусгасан.
		13.Хуулийн төслийн маш олон заалтууд /83 дугаар зүйлээс хойш/-д шүүхээс явуулсан, хэрэг гүйцэтгэгчээс явуулсан ажиллагаанд шүүхэд гомдол гаргахаар зохицуулсан байна. Зарчмын хувьд маргаантай эрх зүйн харилцаа юм уу, маргаангүй эрх зүйн харилцаа байх уу гэдгийг тодруулах. Хэрэв маргаангүй байдлаар, онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх тохиолдолд шүүгчийн гаргасан эрхийн акт, хэрэг гүйцэтгэгчийн явуулсан ажиллагаа бүрт гомдол гаргах нь зохимжгүй байх ба, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмнэлттэй байх зарчимтай нийцэхгүй гэж үзэхээр байна.	Саналыг тусгаагүй. Гомдол маргаантай бол гаргана.
		14.Хуулийн төслийн 8.1-д заасан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 72.1 гэж ямар заалт вэ, ийм заалт байхгүй учир техникийн алдааг залруулах, тус хуулийн яг аль заалт болохыг тодруулах,	Саналыг тусгасан.
		15.Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад болон эцсийн шийдвэр гаргахдаа шүүх хуралдаан хийх эсэх нь тодорхойгүй, хуулийн төслийн 23.1-д зааснаас өөр шүүх хуралдааны зохицуулалт байхгүй, энэ ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд янан шийдвэрлэх тухай хуулийн дагуу явуулах юм уу гэдэг нь тодорхойгүй, уншигдахгүй байна.	Саналыг тусгаагүй. Хуулийн төслийн 3.5-д тусгасан.
		16.Хуулийн төслийн 16.1-д заасан урьдчилсан төлбөрийн хэмжээ тодорхойгүй, энэ нь шүүгчийн эрх хэмжээ байх уу, ямар шалгуур үзүүлэлтийг харгалзах нь тодорхойгүй, төслийн 32.2-т заасны адил эрх бүхий этгээдээс баталсан журмаар зохицуулах уу гэдгийг тодруулж заах.	Саналыг тусгасан.
9.	Монгол банк	Санал ирүүлээгүй.	Санал ирүүлээгүй тул тусгайлан өгөх

			саналгүй гэж үзсэн болно.
10.	Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургууль	Санал ирүүлээгүй.	Санал ирүүлээгүй тул тусгайлан өгөх саналгүй гэж үзсэн болно.
11.	Санхүү, эдийн засгийн их сургууль, отгонтэнгэр их сургууль	Санал ирүүлээгүй.	Санал ирүүлээгүй тул тусгайлан өгөх саналгүй гэж үзсэн болно.
12.	Шихихутаг их сургууль, их засаг их сургууль	Санал ирүүлээгүй.	Санал ирүүлээгүй тул тусгайлан өгөх саналгүй гэж үзсэн болно.
13.	Улаанбаатар хотын худалдааны танхим	Санал ирүүлээгүй.	Санал ирүүлээгүй тул тусгайлан өгөх саналгүй гэж үзсэн болно.
14.	Монголын банкны холбоо	Санал ирүүлээгүй.	Санал ирүүлээгүй тул тусгайлан өгөх саналгүй гэж үзсэн болно.
15.	Монголын хуульчдын холбоо	Санал ирүүлээгүй.	Санал ирүүлээгүй тул тусгайлан өгөх саналгүй гэж үзсэн болно.
16.	Монголын өмгөөлөгчдийн холбоо	Санал ирүүлээгүй.	Санал ирүүлээгүй тул тусгайлан өгөх саналгүй гэж үзсэн болно.
17.	Монгол дахь европын худалдааны танхим	Санал ирүүлээгүй.	Санал ирүүлээгүй тул тусгайлан өгөх

			саналгүй гэж үзсэн болно.
18.	Монгол дахь австралийн худалдааны танхим	Санал ирүүлээгүй.	Санал ирүүлээгүй тул тусгайлан өгөх саналгүй гэж үзсэн болно.

#### МҮХАҮТ-ЫН НАРИЙВЧИЛСАН САНАЛ:

№	Зүйл заалт	Төслийн зүйл заалтын томъёолол	Өөрчлөлт оруулах саналын томъёолол	Саналын тайлбар, үндэслэл	
1.	22.1.	Дараах нөхцөлийн аль нэг бүрдсэн тохиолдолд хуулийн этгээдийг төлбөрийн чадваргүйд тооцож, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлнэ:	Дараах заалтыг хасах.  <del>22.1.1.хууль, эсхүл гэрээнд заасан мөнгөн төлбөрийн үүргээ үргэлжилсэн зургаан сараас дээш хугацаагаар биелүүлж чадаагүй;</del>	Хуулийн төслийн 22.1.1-д заасны дагуу төлбөрийн үүргээ 6 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн тохиолдолд тухайн компанийг төлбөрийн чадваргүйд тооцож, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхээр тусгагдсан. Өөрөөр хэлбэл, тухайн үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадвартай эсэхээс үл хамаараад, төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй нь шууд төлбөрийн чадваргүйд тооцож, ажиллагаа эхлүүлэх үндэслэл болохоор байна.  Энэ нь бусад үүрэг гүйцэтгүүлэгч, болон үүрэг хүлээгчийн хувьд үйл ажиллагаагаа сайжруулах, санхүүгийн боломжийг бий болгох зэрэгт сөргөөр нөлөөлж, шүүхийн	Саналыг тусгаагүй.  Cash flow аргыг балансын аргатай хамт аль альнд нь шийднэ.
	22.1.1.	хууль, эсхүл гэрээнд заасан мөнгөн төлбөрийн үүргээ үргэлжилсэн зургаан сараас дээш хугацаагаар биелүүлж чадаагүй;			

				<p>ачааллыг нэмэгдүүлэх үндэслэл болохоор байна.</p> <p>Иймд төлбөрийн чадваргүйд тооцож, ажиллагаа эхлүүлэх үндэслэлийг зөвхөн 22.1.2-д заасан нэг үндэслэлээр буюу тухайн компанийн төлбөрийн чадварт үндэслэх. 22.1.1-т заасан үндэслэлийг хасах.</p>	
2.	22.1.2.	<p>нийт өр төлбөр нь хуулийн этгээдийн санхүүгийн тайланд тусгагдсан нийт хөрөнгийн дүнгийн 50 хувиас хэтэрсэн- энэ зохицуулалтыг өөрчлөх.</p>	<p>Дараах өөрчлөлтийг оруулах:</p> <p><i>“22.1.2. нийт өр төлбөр нь хуулийн этгээдийн санхүүгийн тайланд тусгагдсан нийт хөрөнгийн дүнгийн ____ хувиас хэтэрсэн.”</i></p> <p>Эсхүл</p> <p><i>“22.1.Өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцож, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлнэ.”</i></p>	<p>Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ заасан хугацаанд биелүүлээгүй бол төлбөрийн чадваргүйд тооцохоор заасан. Уг заалтын дагуу нийт өр төлбөрийн хэмжээ өөрийн хөрөнгийн хэдэн хувийг эзэлж байгаа нь чухал бус, харин үүргийн гүйцэтгэлийг биелүүлэх хугацааг хэтрүүлэх нь төлбөрийн чадваргүйд тооцох гол үндэслэл болж байна.</p> <p>Харин хуулийн төслийн 22.1.1, 22.1.2-оор үүргийн гүйцэтгэл 6 сараас дээш хугацаагаар биелүүлээгүй нь төлбөрийн чадваргүйд тооцох нэг үндэслэл болох бол нийт өр төлбөр нь нийт хөрөнгийн дүнгийн 50 хувиас</p>	Саналыг тусгасан.

				<p>хэтэрсэн тохиолдолд нөгөө үндэслэл болохоор байа.</p> <p>Энэ нь төлбөрийн чадваргүйд тооцогдох эрсдлийг хуулийн этгээдүүдэд ихээхэн нэмэгдүүлж үүсгэж байна.</p> <p>Цаашлаад хуулийн этгээдийн өр төлбөр тавих хэмжээг ийнхүү хуулиар хязгаарласнаар хөрөнгө татан төвлөрүүлж, эргэлдүүлэн бизнес, үйл ажиллагаагаа өргөжүүлэхийг хязгаарлаж байна. Мөн эсхүүргээ хугацаанд нь гүйцэтгэж байгаа хуулийн этгээдүүд балансаас шалтгаалж төлбөрийн чадваргүйд тооцуулах эрсдэлд орох зэрэг асуудал үүсэхээр байгаа тул энэ хувь хэмжээг багасгах, эсхүл өмнөх хуулийн зохицуулалтын адил (i) үүргээ гүйцэтгээгүй, (ii) хугацааг хэтрүүлсэн хоёр нөхцөл зэрэг хангагдсанаар ажиллагаа эхлүүлэхээр зохицуулах.</p>	
3.	57.1.	<p>Үүрэг гүйцэтгүүлэгч төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргахаас өмнөх нэг сарын дотор, эсхүл энэ хүсэлтийг гаргасны дараа</p>	<p>Тус заалтыг хуулийн төслөөс хасах:</p> <p><del>“57.1.Үүрэг гүйцэтгүүлэгч төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргахаас өмнөх нэг сарын</del> </p>	<p>Үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд тухайн хөрөнгийн өмчлөх эрхийг нотолсон баримт буюу улсын бүртгэлийн мэдээллийг үнэн зөв гэж үзэж барьцааны гэрээг байгуулах ба төлбөрийн чадваргүй болох үндэслэл бүрэн бүрдсэн</p>	Саналыг тусгасан.



		үүрэг гүйцэтгэгчийн хуваарилагдах хөрөнгөнд хамаарах хөрөнгөнд барьцааны эрх олж авсан бол уг эрхийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.	<del>дотөр, эсхүл энэ хүсэлтийг гаргасны дараа үүрэг гүйцэтгэгчийн хуваарилагдах хөрөнгөнд хамаарах хөрөнгөнд барьцааны эрх олж авсан бол уг эрхийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.</del>	эсэхийг урьдчилан мэдэх боломжгүй учир түүнтэй байгуулсан гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох нь барьцаалагчийн эрхийг зөрчихөөр байна.  Иймд энэ заалтыг бүхэлд нь хасах саналтай.	
4.	84.1	84.1.Хуваарилагдах хөрөнгөөс нэхэмжлэлийн шаардлагыг дараах дарааллаар хангана:  84.1.1.бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хор, хохирлыг арилгах төлбөр;  84.1.2.төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардал;  84.1.3.татварын болон гаалийн албаны тодорхойлолтоор баталгаажсан татварын ногдол, татварын өр, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, алданги, хүү, торгууль;  84.1.4.ажилтны цалин, олговор, болон хөдөлмөрийн болон	Дараах өөрчлөлтийг оруулах:  “84.1.Хуваарилагдах хөрөнгөөс нэхэмжлэлийн шаардлагыг дараах дарааллаар хангана:  84.1.1. Өмнө шүүхийн шийдвэрээр төлбөр гаргуулахаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон төлбөр авагч, үүрэг гүйцэтгүүлэгч;  84.1.2. Нэхэмжлэлийн шаардлага нь барьцаагаар хангагдах үүрэг гүйцэтгүүлэгч;  84.1.3.бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хор, хохирлыг арилгах төлбөр;  84.1.4. төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардал;  84.1.5.татварын болон гаалийн албаны тодорхойлолтоор	Нэхэмжлэлийн шаардлага барьцаагаар хангагдах үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд тэргүүн ээлжид шаардлагаа хангуулах зохицуулалтыг тусгах саналтай ба тухайн барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь хангахад хүрэлцэхгүй тохиолдолд бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн адил энгийн дарааллаар, нэхэмжлэл гаргасан хугацааны дарааллаар орж, нэхэмжлэлийн шаардлагагаа хангуулах боломжийг олгох зорилгоор өөрчлөлт оруулах саналыг тусгав.  Түүнчлэн төлбөрийн чадваргүйдлын ажиллагаа эхлүүлснээс хойш бий болсон өр төлбөр нь нэхэмжлэлийн шаардлага хангуулах энгийн үүрэг гүйцэтгүүлэгчийн араас дараалах нь зүйтэй гэж үзэж дарааллын хувьд өөрчлөлт оруулав.	Саналыг тусгаагүй. ШШГТх-ийн төсөлд тусгасан. Сангийн яам мөн зөвшөөрөхгүй.

		<p>хамтын гэрээгээр хүлээсэн бусад өр төлбөр;</p> <p>84.1.5.үүрэг гүйцэтгэгчийг дахин хөрөнгөжүүлэх болон дахин зохион байгуулах зорилгоор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлснээс хойш бий болсон өр төлбөр;</p> <p>84.1.6.нэхэмжлэлийн шаардлагын бүртгэлд орсон энгийн үүрэг гүйцэтгүүлэгчдийн шаардлага;</p> <p>84.1.7.барьцаа хөрөнгийн үнэлгээний зөрүүгээр төлөгдөөгүй үлдсэн өр төлбөр.</p>	<p><i>баталгаажсан татварын ногдол, татварын өр, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, алданги, хүү, торгууль;</i></p> <p><i>84.1.6.ажилтны цалин, олговор, болон хөдөлмөрийн болон хамтын гэрээгээр хүлээсэн бусад өр төлбөр;</i></p> <p><i>84.1.7.нэхэмжлэлийн шаардлагын бүртгэлд орсон энгийн үүрэг гүйцэтгүүлэгчдийн шаардлага болон барьцаа хөрөнгийн үнэлгээний зөрүүгээр төлөгдөөгүй үлдсэн өр төлбөр;</i></p> <p><i>84.1.8.үүрэг гүйцэтгэгчийг дахин хөрөнгөжүүлэх болон дахин зохион байгуулах зорилгоор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлснээс хойш бий болсон өр төлбөр;”</i></p>		
5.	39.1	<p>Үүрэг гүйцэтгүүлэгч шаардлагаа энэ хуулийн 24.3-т заасан шаардлага гаргах сүүлчийн өдрөөс хойш боловч баталгаажуулах хурал болохоос гурваас доошгүй хоногийн өмнө гаргасан нь</p>	<p>Төслийн 39.1-д дараах агуулгыг нэмж тусгах.</p> <p><i>“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дагуу барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулах</i></p>	<p>Одоогийн хуулийн хүрээнд дампуурлын хэрэг үүссэн тохиолдолд өмнөх шийдвэр гүйцэтгэх ажиллалааг түдгэлзүүлж байна.</p> <p>Иргэний болон захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулийн</p>	Саналыг тусгасан.

		хүндэтгэн үзэх шалтгаантай бол хэрэг гүйцэтгэгч хүлээн авч баталгаажуулах хуралд танилцуулна.	<i>төлбөр авагч нь гэрээний төлбөр төлөх үүрэг барьцаа хөрөнгөөс хангуулахад хүрэлцээгүй болох нь тогтоогдсон тохиолдолд төлбөрийн чадваргүйдлын ажиллагаанд нэхэмжлэгчээр оролцох хүсэлт гаргах, шаардлага гаргах эрхтэй.</i>	<p>төсөлд хэрэв тухайн төлбөр нь шүүхийн шийдвэрийн дагуу барьцаа хөрөнгөөр гаргуулах тохиолдолд тухайн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзэх үндэслэлд хамаарахгүй байхаар зохицуулсан.</p> <p>Төлбөр авагч буюу үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд өмнө шүүхийн шийдвэрээр төлбөр авах, тухайн төлбөрийг барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шийдвэрлэсэн боловч тухайн барьцаа хөрөнгө төлбөрийг төлөхөд бүрэн хүрэлцэхгүй болохыг мэдэх боломжгүй учир төлбөрийн чадваргүйдлын ажиллагаанд оролцох, нэхэмжлэлийн шаардлагын дүн тодорхойгүй байх зэрэг асуудал үүсэх боломжтой.</p> <p>Иймд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа хэргийн хувьд барьцаагаар хангуулахад хүрэлцэхгүй байгаа шаардлагатай нэхэмжлэгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оруулах, түүнчлэн нэхэмжлэгчдийн дарааллын хувьд энгийн дараалалд хамааруулах байдлаар зохицуулалт тусгах саналтай.</p>	
--	--	---	--	--	--

6.	75.1.	Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлснээс хойш 28 хоногийн дотор хэрэг гүйцэтгэгч хөрөнгө тус бүрийн зах зээлийн үнэ ба хөрөнгийн элэгдэл, чанар, хэрэгцээг харгалзан үнэлж, хуваарилагдах хөрөнгийг бүртгэнэ.	75 дугаар зүйлд дараах агуулгыг нэмж тусгах:  “*.*. Хөрөнгийн үнэлгээний дүнд эрх бүхий этгээд хяналт тавина.”  “*.*. Хэрэв энэ хуулийн 75.4-т заасан үнэлгээ нь үндэслэлгүй гэж үзвэл хэргийн оролцогч этгээд энэ талаар шүүхэд гомдол гаргах эрхтэй.”  “*.*. Шүүх гомдлыг хянаад үндэслэлтэй гэж үзвэл хөрөнгийн үнэлгээг хүчингүйд тооцох ба хөрөнгийн үнэлгээчинд хариуцлага тооцно.”	Хуулийн төслийн 75.1 дахь хэсэгт хэрэг гүйцэтгэгч хөрөнгийн үнэлгээг өөрөө хийх, 75.4-т хэрэг гүйцэтгэгч бие даан үнэлэх, хөрөнгийн зах зээлийн үнэлгээг тогтооход хүндрэлтэй бол хөрөнгийг үнэлүүлэхээр хөндлөнгийн үнэлгээчин томилж болно гэж заасан байна.  Хэрэг бүрд хөрөнгийн үнэлгээг хөндлөнгийн үнэлгээчнээр хийлгэх нь санхүүгийн хувьд хүндрэлтэй байх тул уг зохицуулалтыг санал болгохгүй.  Харин хэрэг гүйцэтгэгчийн болон хөндлөнгийн үнэлгээчний хийсэн хөрөнгийн үнэлгээтэй танилцаж, хяналт тавин хөрөнгийн үнэлгээг үндэслэлгүй тогтоосон шалтгаанаар шүүхэд гомдол гаргах, санаатай үйлдэл байх тохиолдолд хариуцлага тооцуулах зэрэг зохицуулалт нэмэх саналтай байна.	Зарчмын хувьд тусгасан.
	75.4.	Хэрэг гүйцэтгэгч бие даан үнэлэх, хөрөнгийн зах зээлийн үнэлгээг тогтооход хүндрэлтэй бол хөрөнгийг үнэлүүлэхээр хөндлөнгийн үнэлгээчин томилж болно. Хөрөнгийн үнэлгээчний тогтоосон үнэ эцсийнх байна			Саналыг тусгасан.
7.	75.4	Хэрэг гүйцэтгэгч бие даан үнэлэх, хөрөнгийн зах зээлийн үнэлгээг тогтооход хүндрэлтэй бол хөрөнгийг үнэлүүлэхээр хөндлөнгийн үнэлгээчин томилж болно. Хөрөнгийн	Дараах өөрчлөлтийг оруулах:  “75.4.Хөрөнгийн зах зээлийн үнэлгээг тогтооход хөндлөнгийн үнэлгээчинг томилох бөгөөд Хөрөнгийн	Герман улсын дампуурлын ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах үүднээс хөрөнгийн үнэлгээ хийхэд хөндлөнгийн үнэлгээчид оролцохыг шаарддаг бөгөөд хөрөнгийг үнэлэхдээ зах зээлийн	Саналыг тусгасан.

		үнэлгээчний тогтоосон үнэ эцсийнх байна.	үнэлгээчний тогтоосон үнэ эцсийнх байна.”	үнэ болон хөрөнгийн ашиглалтын байдал зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үздэг.  Тиймээс, үнэлгээний процессийн ил тод байдлыг хангах үүднээс хуулийн төслийн 75.4-ийн заалтыг илүү тодорхой болгож, хөрөнгийн үнэлгээчинг оролцохыг сонголт байдлаар бус заавал оролцуулах байдлаар өөрчлөх саналтай байна.	
8.	79.2	Хэрэг гүйцэтгэгч нь хуваарилагдах хөрөнгийг худалдахдаа хөрөнгийн шинж чанарыг харгалзан тухайн нөхцөл байдалд тохирох аргыг сонгох, мэргэшсэн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх зэргээр аль болох зардал багатай, шударгаар худалдах оновчтой арга хэрэгслийг сонгох үүрэгтэй.	Дараах өөрчлөлтийг оруулах:  “79.2.Хэрэг гүйцэтгэгч нь хуваарилагдах хөрөнгийг худалдахдаа хөрөнгийн шинж чанарыг харгалзан тухайн нөхцөл байдалд тохирох аргыг сонгох, мэргэшсэн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх зэргээр аль болох зардал багатай, шударгаар, зах зээлийн үнэлгээнд нийцүүлэн худалдах оновчтой арга хэрэгслийг сонгох үүрэгтэй.”	Германы дампуурлын хууль нь хуваарилагдах хөрөнгийг эдийн засгийн ач холбогдолтой, зах зээлийн үнэд нийцүүлэн зарж борлуулах, хуваарилах үйл ажиллагаанд оролцох байгууллагуудыг тодорхой зааж өгдөг.  Иймд зах зээлийн үнэлгээнд нийцүүлэн гэсэн нөхцөлийг нэмж хуульд тусгах нь саналтай байна.	Саналыг тусгасан.
9.	74.2	Хэрэг гүйцэтгэгч хөрөнгийг битүүмжлэх, битүүмжлэлээс чөлөөлөх ажиллагааг тэмдэглэл үйлдэн баримтжуулж,	Дараах өөрчлөлтийг оруулах:  “74.2. Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр хэрэг гүйцэтгэгч	Олон улсын практикт, Герман болон Япон Улсын Дампуурлын хуулиудад заасны дагуу хөрөнгийг битүүмжлэх, чөлөөлөх үйл явцыг шүүхийн хатуу хяналт дор	Саналыг тусгасан.

		хэргийн оролцогчдод танилцуулах зорилгоор шүүхэд хүргүүлнэ.	<i>хөрөнгийг битүүмжлэх, битүүмжлэлээс чөлөөлөх ажиллагааг тэмдэглэл үйлдэн баримтжуулж, хэргийн оролцогчдод танилцуулах зорилгоор шүүхэд хүргүүлнэ.”</i>	явуулдаг. Хөрөнгийг битүүмжлэх арга хэмжээг зөвхөн шүүхийн шийдвэрээр хийх шаардлагатай бөгөөд энэ нь хууль зүйн эрсдлийг бууруулж, бүх оролцогч талуудын эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой.	
10.	12.1	Үүрэг гүйцэтгүүлэгч төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг шүүхэд гаргах эрхтэй.	Дараах өөрчлөлтийг оруулах:  <i>“Үүрэг гүйцэтгэгч хууль, эсхүл гэрээнд заасан мөнгөн төлбөрийн үүргээ 6 сараас дээш хугацаагаар биелүүлээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг шүүхэд гаргах эрхтэй.”</i>	Үүрэг гүйцэтгүүлэгч шүүхэд хүсэлт гаргах хугацааг тодорхой болгосноор үүрэг гүйцэтгэгчийг төлбөрийн чадваргүй болсон гэж үзэх нөхцөл бүрдээгүй үед шүүхэд хүсэлт гаргаж, шүүх ажиллагаа эхлүүлэхээс татгалзах нөхцөл үүсэхээс сэргийлэх боломжтой гэж үзэж байна.	Саналыг тусгасан.
11.	12.2	Үүрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэх удирдлага төлбөрийн чадваргүй болсныг мэдсэн буюу мэдэх боломжтой байсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг шүүхэд гаргах үүрэгтэй.	Дараах заалтыг хуулийн төсөлд шинээр нэмэх:  <i>“*. *. Энэ хуулийн 12.2-т заасан хугацааг зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн бол үүрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэх удирдлага хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт шүүхэд гаргаж болох бөгөөд шүүгч уг хугацааг хэтэрснээс хойш .....</i>	Тус заалтад 45 хоногийн дотор хүсэлтээ шүүхэд гаргаагүй хугацаа хэтрүүлсэн тохиолдолд хэрхэх талаар зохицуулаагүй байна.  Энэ нь 45 хоногийн дотор багтаж хүсэлтээ өгөөгүй бол хуулийн этгээд өөрийн санаачилгаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх боломжгүй болох, мөн гүйцэтгэх удирдлага нь хувийн хөрөнгөөрөө өр төлбөрийг хариуцах үр дагаврыг үүсгэхээр байна.	Саналыг тусгаагүй.

			<i>хугацааны дотор нөхөн сэргээж болно.”</i>	Иймд мэдээгүй, мэдэх боломжгүй байсан болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хугацаа сэргээх боломжтой заалт нэмэх саналтай байна.	
12.			12.2 дахь хэсэгт дараах өөрчлөлтийг оруулах:  <i>“12.2. Үүрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигч нь төлбөрийн чадваргүй болсныг мэдсэн буюу мэдэх боломжтой байсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг шүүхэд гаргах үүрэгтэй.”</i>	Тус заалтад компанийн хувьцаа эзэмшигч хүсэлт гаргах эрхтэй байдлаар нэмж зохицуулах саналтай.	Саналыг тусгасан.
13.	14.4.	Энэ хуулийн 12.2-т заасан үүргээ биелүүлээгүйн улмаас үүрэг гүйцэтгүүлэгчид учруулсан хохирлыг хүсэлт гаргах үүрэг бүхий гүйцэтгэх удирдлага хувийн хөрөнгөөрөө хариуцна.	Дараах өөрчлөлтийг оруулах:  <i>“14.4. Энэ хуулийн 12.2-т заасан үүргээ биелүүлээгүйн улмаас үүрэг гүйцэтгүүлэгчид учруулсан хохирлыг хүсэлт гаргах үүрэг бүхий гүйцэтгэх удирдлага, эсхүл хувьцаа эзэмшигч хувийн хөрөнгөөрөө хариуцна.”</i>	Компанийн эцсийн өмчлөгч болох хувьцаа эзэмшигч нь төлбөрийн чадваргүйд тооцуулахаар хүсэлт гаргах боломжийг тусгаж, тухайн хуулийн хугацаанд хүсэлт гаргаагүй бол хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх удирдлага өөрийн хувийн хөрөнгөөр хариуцлага хүлээх зохицуулалтыг нэмж тусгах.	Саналыг тусгасан.
14.	15.1.	Шүүх хүсэлтийг 10 хоногийн дотор хянаж,	Дараах заалтыг хуулийн төсөлд шинээр нэмэх:	Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхэд хоёр	Саналыг тусгасан.

		дараах үндэслэл байвал хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, захирамж гаргана:	<p><i>“15.1. Шүүх хүсэлтийг 10 хоногийн дотор хянаж, дараах үндэслэл байвал хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, захирамж гаргана:</i></p> <p><i>15.1.10. энэ хуулийн 22.1-т заасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх үндэслэл бүрдээгүй.”</i></p>	<p>урьдчилсан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн байх талаар хуулийн төслийн 22.1-т заасан боловч хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, захирамж гаргах үндэслэлд оруулаагүй нь уг заалт хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.</p> <p>Иймд үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч нараас гарсан хүсэлтийг хянахад 22.1-т заасан нөхцөл бүрдээгүй байх тохиолдолд хэрэг үүсгэхээс татгалзах захирамж гаргах зохицуулалтыг нэмэх саналтай.</p>	
15.	24.9.	Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангах төлбөрийн чадвартай нь илт байхад төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг үүрэг гүйцэтгэгч гаргасан, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгчийн гаргасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх тухай хүсэлтэд хариу тайлбар гаргаагүйн улмаас төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлсэнтэй	Уг заалттай холбоотойгоор санаатайгаар дампуурсан нөхцөлийг үүрэг гүйцэтгүүлэгч, хэрэг гүйцэтгэгч нар мэдсэн тохиолдолд шинээр илэрсэн нөхцөл байдлыг хянуулахаар шүүхэд нэхэмжлэл, хүсэлт гаргах талаар зохицуулалтыг нэмэх.	<p>Үүрэг гүйцэтгэгч төлбөрийг төлөхөөс зайлсхийх, хууран мэхлэх замаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг санаачлан эхлүүлж, төлбөрийн чадваргүйд тооцуулсан, ажиллагааг дуусгаж, улсын бүртгэлээс хасуулсан зэрэг нөхцөл үүссэн үед уг дампуурал нь санаатай, хуурамч байсныг үүрэг гүйцэтгүүлэгч болон хэрэг гүйцэтгэгч хожим олж мэдсэн тохиолдолд хэдийд ч шүүхэд нэхэмжлэл гаргаж, хэргийг дахин хэлэлцүүлж учирсан хохирлоо арилгуулах боломжийг олгосон</p>	Саналыг тусгаагүй. Хуулийн төсөлд тусгасан.



		холбогдон бусад үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан хохирлыг үүрэг гүйцэтгэгч нөхөн төлнө.		зохицуулалтыг хуульд нэмэх саналтай байна.	
16.		Хэрэг гүйцэтгэгчийг ажлаас нь чөлөөлөх үндэслэлд нэмэх заалт санал	Дараах заалтыг хуулийн төсөлд шинээр нэмэх:  <i>“30.1.Дараах тохиолдолд шүүгч санаачилгаараа, эсхүл хэрэг гүйцэтгэгчийн хүсэлт, үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлаас гаргасан саналыг үндэслэн хэрэг гүйцэтгэгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх захирамж гаргана:</i>  <i>30.1.5 үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулсан, завшсан;”</i>	Үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгийг захиран зарцуулах эрх хэрэг гүйцэтгэгчид шилжих тул хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, үүрэг гүйцэтгэгчид хохирол учрахаас хамгаалах зорилгоор уг зохицуулалтыг нэмэх саналтай ба уг хариуцлага дээр нэмээд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр дампуурлын хэргийн оролцогчид гомдол, мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдүүлэх талаар мөн зохицуулах, эсхүл эрүүгийн хуулийг заан тусгуулах.	Саналыг тусгасан.
17.	9.3	Энэ хуулийн 9.1-д заасны дагуу нийтэд мэдээлснийг мэдээллийн бусад эх сурвалжид эш татахыг хориглоно.	Дараах заалтыг хасах:  <del><i>“9.3.Энэ хуулийн 9.1-д заасны дагуу нийтэд мэдээлснийг мэдээллийн бусад эх сурвалжид эш татахыг хориглоно.”</i></del>	Тус заалтын агуулга буюу бусад эх сурвалж гэдэгт ямар этгээд орох нь ойлгомжгүй, тодорхойгүй байна.  Тодруулбал, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны талаар нийтэд мэдээллэсэн мэдээ, мэдээллийг гуравдагч этгээд эшлэх боломжгүй гэж ойлгогдож байна.	Саналыг тусгасан.
	9.1	Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төлбөрийн чадваргүйдлийн талаар ажиллагааны талаар нийтэд мэдээлэхээр			

		заасан мэдээллийг шүүхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагын цахим хуудас, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд шүүгчийн захирамж гарсан өдрөөс хойш тав хоногийн дотор байршуулна.		Иймд тус зүйл заалт нь хэвлэл, мэдээллийн эрх чөлөөнд халдаж болохуйц заалт тул хасах саналтай байна.	
18.	13.2.7.	Энэ хуулийн 13.1-д заасан хүсэлтэд дараах зүйлийг тусгасан байна:  13.2.7. хавсаргасан баримт бичгийн жагсаалт.	13.3. дахь хэсгийг хасах:  <del>“13.3.Энэ хуулийн 13.2.7-д заасан баримт бичигт дараах баримт бичиг хамаарна:</del>	Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтэд хавсаргасан баримтын жагсаалт (13.2.7)-ыг тусгахаар оруулсан. Улмаар хавсаргасан баримтын жагсаалт гэдэгт төслийн 13.3-т заасан дөрвөн төрлийн баримтыг нэрлэн заажээ.  Гэвч хүсэлт гаргахад зөвхөн 13.3-д зааснаар хязгаарлагдахгүй нэмэлт бусад баримтууд хавсаргах боломжтой.  Иймд хүсэлтэд зөвхөн 13.3-д заасан жагсаалтыг хавсаргахаар хязгаарласан байгааг хасах эсхүл заалтын томъёололд нь өөрчлөлт оруулах.	Саналыг тусгаагүй.
	13.3	Энэ хуулийн 13.2.7-д заасан баримт бичигт дараах баримт бичиг хамаарна:  13.3.1.тухайн шаардлагын талаар өмнө нь шүүхийн шийдвэр гарч байсан бол уг шийдвэр;  13.3.2.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад явуулсан гүйцэтгэх хуудас;  13.3.3.шаардах эрх нь барьцаагаар хангагдсан	<del>13.3.1.тухайн шаардлагын талаар өмнө нь шүүхийн шийдвэр гарч байсан бол уг шийдвэр; 13.3.2.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад явуулсан гүйцэтгэх хуудас; 13.3.3.шаардах эрх нь барьцаагаар хангагдсан бол энэ тухай тайлбар, холбогдох нотлох баримт; 13.3.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл уг хураамжаас чөлөөлүүлэх, хөнгөлүүлэх, хэсэгчлэн төлөх;</del>		

		бол энэ тухай тайлбар, холбогдох нотлох баримт; 13.3.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл уг хураамжаас чөлөөлүүлэх, хөнгөлүүлэх, хэсэгчлэн төлөх, төлөх хугацааг хойшлуулах хүсэлт	<del>төлөх хугацааг хойшлуулах хүсэлт</del>  <b>эсхүл</b> дараах өөрчлөлтийг оруулах:  “13.3.Энэ хуулийн 13.2.7-д заасан баримт бичигт дараах болон хүсэлт гаргагчийн бусад хавсаргасан баримт бичиг хамаарна.”		
19.	23.1	Шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх захирамж гаргахын өмнө төлбөрийн чадваргүй болсон шалтгааныг тодруулах зорилгоор хүсэлт гаргагч болон үүрэг гүйцэтгэгчийг оролцуулан <b>шүүх хурал</b> хийж болно.	Тодорхойгүй нөхцлийг арилгаж, холбогдох заалтуудад өөрчлөлт оруулах	Хуулийн төслийн 23.1-т шүүх хурлыг хийж болно гэж зохицуулаад, 24.1-т тус шүүх хурлыг хийсэн эсхүл хийгээгүй гэж хоёр талтай зохицуулсан байна.  Өөрөөр хэлбэл, хурал хийх эсэх талаар тодорхой шалгуур байхгүй хурал хийх эсэхийг шүүгч үзэмжээрээ шийдвэрлэх тохиолдолд хууль хэрэглээний нэгдмэл бус практик үүсэх эрсдэлтэй.  Иймд уг хурлыг заавал хийх шаардлагыг судлан, заавал хийх шаардлагагүй тохиолдолд хийхгүй байхаар зохицуулах.  Эсхүл “зайлшгүй хийх шаардлагатай” болон “хийхгүй байж болох” тохиолдлоос сонгох	Саналыг тусгаагүй. Хуулийн төсөлд тусгасан.
	24.1	Шүүх энэ хуулийн 23.1-д заасан хурал болсон өдрөөс хойш, эсхүл хурал хийгээгүй бол түр хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлт гарсан өдрөөс хойш тав хоногийн дотор энэ хуулийн 22.1-д заасан үндэслэлээр төлбөрийн			Саналыг тусгаагүй. Хуулийн төсөлд тусгасан.

		чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх <b>захирамж</b> гаргана.		суурь шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох.	
20.	37	<b>Баталсан шаардлага</b> 37.1.Хэрэг гүйцэтгэгч нэхэмжлэлийн шаардлагыг баталсан бол маргаангүйд тооцож, энэ хуулийн 49.1.1-д заасан баталгаажуулах хуралд танилцуулна.	Төслийн 37, 38 дахь заалтыг илүү болгож, нарийвчлан тусгах	Төслийн 37, 38-д Хэрэг гүйцэтгэгч нь нэхэмжлэлийн шаардлагыг батлах эрхийг эдлэхээр байгаа нь ойлгомжгүй байна. Энэ нь хэрэг гүйцэтгэгчийн субъектив үнэлэмжээр шийдвэрлэгдэх, хэргийн бусад оролцогчоос нөлөөлөх зэрэг эрсдэл үүсгэх боломжтой.  Ийм ямар үндэслэл бүрдсэн тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагыг батлах, батлахгүй байх үндэслэл, шаардлагыг нарийвчлан тусгах шаардлагатай.  Түүнчлэн хэрэг гүйцэтгэгч нь шүүхийн эрх хэмжээнээс давсан эрх хэмжээтэй байх эсэхийг тодорхойлж, ялгаатай байдлаар зохицуулалтыг тусгах саналтай.	Саналыг тусгаагүй. Хуулийн төсөлд тусгасан.
	38	<b>Маргаантай шаардлага</b> 38.1.Нэхэмжлэлийн шаардлагыг хэрэг гүйцэтгэгч батлаагүй бол маргаантай шаардлагад тооцно.			Саналыг тусгаагүй. Хуулийн төсөлд тусгасан.
21.	4.1.2.	"үүрэг гүйцэтгэгч" гэж төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийг;	Дараах өөрчлөлтийг оруулах:  <i>"4.1.2. "үүрэг гүйцэтгэгч" гэж төлбөрийн чадваргүй болох эрсдэлд орсон хуулийн этгээдийг;"</i>	Уг хуулийн төслийн хүрээнд төлбөрийн чадваргүй гэж тогтоогдохоос өмнөх харилцааг мөн зохицуулсан. Иймд үүрэг гүйцэтгэгчийг тодорхойлохдоо шууд төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээд гэх нь зөвхөн нэг талыг баримталсан болох тул төлбөрийн чадваргүй болох	Саналыг тусгасан.

				эрсдэлд орсон хуулийн этгээд гэж өөрчлөн томьёолох саналтай байна.	
22.	31.1	Шүүх хэрэг гүйцэтгэгчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавина.	Дараах өөрчлөлтийг оруулах:  “31.1 _____ хэрэг гүйцэтгэгчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавина.”	Шүүх хэрэг гүйцэтгэгчид хяналт тавьж байгаа нь шүүхийн хөндлөнгийн байр сууринаас ажиллах, хараат бус байх үйл ажиллагааны зарчимтай зөрчилдөхөөр байна.	Саналыг тусгасан.
	27.2.	Хэрэг гүйцэтгэгчийн эрх олгох, сонгон шалгаруулах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“*. *. Энэ хуулийн 31.1-д заасан хяналт тавих үйл ажиллагаатай холбоотой журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”	Иймд хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын томилсон этгээдээр хяналт тавиулах, хяналт тавих журмыг нь 27.2- заасан эрх олгох журамтай хамт эсвэл тусад нь батлуулж, тухайн журмаар хэрэг гүйцэтгэгчдийн мөрдөх зарчмыг нарийн зохицуулах саналтай байна.	
23.	32.1	Хэрэг гүйцэтгэгч нь ажил үүргээ гүйцэтгэсний төлөө ажлын хөлс авах, гарсан зардлаа төлүүлэх эрхтэй. Ажлын хөлсний хэмжээг түүнийг томилох үед шүүх тогтооно.	Дараах өөрчлөлтийг оруулах:  “32.1.Хэрэг гүйцэтгэгч нь ажил үүргээ гүйцэтгэсний төлөө ажлын хөлс авах, гарсан зардлаа төлүүлэх эрхтэй. Ажлын хөлсний хэмжээг түүнийг томилох үед _____ байгууллага тогтооно.”	Хуулийн төсөлд хэрэг гүйцэтгэгчийг хэргийн оролцогчоор тодорхойлсон. Гэтэл шүүх нь хэргийн оролцогчийн ажлын хөлсийг тогтоох зохицуулалт байгаа нь талуудын хараат бус байдалд нөлөөлөх эрсдэлтэй гэж. Иймд Хууль зүйн яамнаас томилсон, эрх олгосон хэрэг гүйцэтгэгч нарыг зохицуулах, баталгаагаар хангах үүрэгтэй	Саналыг тусгаагүй.

				<p>захиргааны байгууллага байх нь зүйтэй.</p> <p>Практикт хэрэг гүйцэтгэгч төлбөрөө үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч нараас авч чадахгүй байх, төлбөргүй ажиллах зэрэг хүндрэл үүсдэг.</p> <p>Иймд хэрэг гүйцэтгэгч нарт тодорхой хэмжээний тогтмол цалин хөлсийг төсвөөс олгох, ажилласан хэргийн төлбөр, зардлыг талуудаас заавал гаргуулж хэрэг гүйцэтгэгчид олгох талаар хууль, журмаар нарийвчлан зохицуулах, уг асуудлыг хариуцаж, санаа тавих тодорхой этгээдийг томилуулах саналтай байна.</p>	
24.	33.1	Хэрэг гүйцэтгэгч үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөхдөө үйл ажиллагааныхаа талаар үүрэг гүйцэтгүүлэгчдийн хуралд тайлагнаж, тооцоо нийлнэ.	Дараах өөрчлөлтийг оруулах: <i>“33.1. Хэрэг гүйцэтгэгч үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөхдөө үйл ажиллагааныхаа талаар _____-д тайлагнаж, тооцоо нийлнэ.”</i>	<p>Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс батлах журамд нэмэлтээр хэрэг гүйцэтгэгчийн ажлыг үнэлэх ерөнхий аргачлалыг баталж, дээр заасан томилогдсон эрх бүхий захиргааны байгууллага ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж, хэрэг гүйцэтгэгч түүний өмнө ажлаа тайлагнах байдлаар зохицуулах саналтай байна.</p> <p>Үүрэг гүйцэтгүүлэгч нар ажлын тайланг хүлээн авч тооцоо нийлэх</p>	<p>Саналыг тусгаагүй.</p> <p>Олон улсдаа үүрэг гүйцэтгүүлэгчгүй хуралд танилцуулдаг.</p>

				<p>нь үүрэг гүйцэтгэгчээс ихээхэн хамаарах буюу тэдний үнэлгээнд үүрэг гүйцэтгэгчийн төлбөрөө төлсөн эсэх асуудал гол жинг эзлэх магадлалтай тул дээрх саналыг гаргаж байна. Мөн 31 дүгээр зүйлд заасан хяналтыг ч уг байдлаар зохицуулах саналтай болно.</p>	
--	--	--	--	---	--